

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Хавсралт 4. Ногоон хотууд хөтөлбөрийн Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)

Товчилсон нэрийн жагсаалт

БАТ	Боломжит арга технологи
ЗАУАХТЗОУХК	Зэрлэг амьтны ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлсийн олон улсын худалдааны тухай конвенц
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
ЕСБХБ	Европын сэргээн босголт хөгжлийн банк
ДН	Давсан нийцэл
ЕК	Европын комисс
ЕЭЗХ	Европын эдийн засгийн холбоо
ЕХ	Европын холбоо
БОНАТ	Байгаль орчин, нийгмийн ажлын төлөвлөгөө
ЭХҮК	Эрчим хүчний үйлчилгээ үзүүлэгч компани
БОТБГ	Байгаль орчин, тогтвортой байдлын газар
БОНХШ	Байгаль орчин нийгмийн хяналт шалгалт
БОННУ	Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ
БОНМХС	Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ ба систем
БОНМХ	Байгаль орчин, нийгмийн менежментийн хүрээ
БОНМТ	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө
БОНМС	Байгаль орчин, нийгмийн менежментийн систем
БОНБ	Байгаль орчин, нийгмийн бодлого
БОНТБХ	Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын хүрээ
ЕХ	Европын холбоо
ЭХҮАҮАӨ	Эрчим хүчний үр ашиг, уур амьсгалын өөрчлөлт
БО ба Н	Байгаль орчны ба Нийгмийн
БН	Бүрэн нийцсэн
СЗ	Санхүүгийн зуучлал
ХЮБНУ	Хуучин Югославын бүгд найрамдах улс
НХАТ	Ногоон хотын ажлын төлөвлөгөө
НУАС	Ногоон уур амьсгалын сан
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ОУСТ	Олон улсын сайн туршлага
ОУСБ	Олон улсын санхүүгийн байгууллага
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
ОУТБ	Олон улсын тэнгисийн байгууллага
км	Километр
ГТҮ	Гүйцэтгэлийн түлхүүр үзүүлэлт
АСТ	Амжиргаа сэргээх төлөвлөгөө
ДХОБУСОУК	Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын конвенци
МҮН	Материаллаг үл нийцэл
ОСБ	Ойлголцлын санамж бичиг
ЭХ	Энд хэрэглэгдэхгүй

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

А	Анхааралд
СГБ	Санал гаргах боломжгүй
ХН	Хэсэгчлэн нийцсэн
ПХБ	Полихлорт бифенил
ТГМ	Төслийн гомдлын механизм
Б	Барамнас
ОЗБ	Озоны үе давхарга задлагч бодис
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
НШҮАТ	Нүүлгэн шилжүүлэлтийн үйл ажиллагааны төлөвлөгөө
НШЗ	Нүүлгэн шилжүүлэлтийн зарчим
ТХББ	Төслийн хураангуй барим бичиг
ТТОТ	Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө
ДХААХОУК	Далайд хүний аюулгүй ажиллагааг хангах тухай олон улсын конвенци
тСО ₂ эк	нэг тон СО ₂ эквивалент
АТ	Ажлын тодорхойлолт

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

БОНМС-ийн Гүйцэтгэлийн хураангуй

ЕСБХБ нь Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ) болон Гүйцэтгэлийн шаардлагуудыг багтаасан Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын хүрээ (БОНТБХ)-г Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), Екуадор Банкс зэрэг олон улсын санхүүгийн бусад байгууллагууд (ОУСБ)-ынхтай нийцүүлэн цогцоор нь боловсруулан баталсан. Түүнчлэн ЕСБХБ нь Байгаль орчин, нийгмийн зарчмуудыг хангасан ба эдгээр зарчмууд нь төслүүдэд БОНБ-ын хүрээний дагуу боловсруулалт хийж, хяналт тавих процессийг тодорхойлсон болно.

ЕСБХБ-аас санхүүжүүлж болох эсэхийг шийдвэрлэхэд тус дөхөм болох үүднээс, мөн санхүүжилт хийгдэх тохиолдолд төслийн төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагааны явцад байгаль орчин, нийгмийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор бүх төсөлд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийдэг. Үнэлгээ нь байгаль орчин, нийгмийн боломжуудыг ч мөн тодорхойлдог. ЕСБХБ нь БОНТБХ, байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон мониторингийн бодлогын хүрээнд тухайн төслүүдийг холбогдох хууль, журам болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх нөхцөлийг хангахын төлөө ажиллана.

ЕСБХБ нь нийгмийн үнэлгээ хийх туршлагатай байгууллага юм. Судалгаа болон фокус бүлгийн ярилцлага зэрэг хэрэгслээр дамжуулан төслийн үйл ажиллагааны нийгмийн өөр өөр бүлгүүд, ялангуяа нэн эмзэг бүлгийнхэнд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж, үнэлнэ. Улмаар нөлөөлөлд өртсөн бүлгүүдтэй зөвлөлдөн нөлөөллийг бууруулах тохиромжтой арга хэмжээг тодорхойлж, хэрэгжүүлнэ. Ийм үнэлгээг хийж, хүмүүсийн хүсэл эрмэлзэл, тэргүүлэх зорилгыг сайтар ойлгож мэдсэнээр тэдний аж амьдралын нийгэм-эдийн засгийн чанарыг дээшлүүлэх боломжтой болох юм.

1. Хөтөлбөрийн үндэслэл ба танилцуулга

1.1 Үндэслэл

СОР12 Парисийн хэлэлцээрт заасанчлан хотууд нь “тогтвортой хөгжил, хүчин чармайлтаар ядуурлыг бууруулахдаа уур амьсгалын өөрчлөлтөд хандах дэлхий нийтийн хандлага, хариу арга хэмжээг дээшлүүлэх”-д нэн чухал үүрэг гүйцэтгэдэг. Хэлэлцээрт нэгдэн орсон Дундад Ази, Хойд Африк, Төв Ази болон зүүн өмнөд Европ (“Хөтөлбөрийн бүс”) зэрэг улсуудын хотууд дэлхийн дунджаас хол давсан эрчим хүчний хэрэглээ, нүүрстөрөгчийн эрчимтэй ялгарлыг бууруулах ижилхэн сорил бэрхшээлтэй нүүр тулаад байна. Үүний сацуу эдгээр хотуудад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс өгсүүлээд агаарын чанар муудсанаас иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан байдал доройтох зэрэг байгаль орчин, нийгмийн олон тулгамдсан асуудал нүүрлээд байгаа юм.

Хотын захиргааны болон байгаль орчны дэд бүтцэд хөрөнгө оруулж, жилд 700 сая гаруй еврогийн хөрөнгө оруулалт хийж, 800,000 тонн нүүрсхүчлийн хийг бууруулах 25 жилийн туршлагатай ЕСБХБ нь Ногоон хотууд хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах харилцаа холбоо, арга хэрэгсэл, мэргэшсэн ур чадварыг ханган бүрдүүлж чадсан билээ.

Энэхүү Хөтөлбөр нь бусад хотуудад авч хэрэгжүүлэх болон үлгэрлэн дуурайх загвар, хөрөнгө оруулалтыг бий болгохуйц хот төлөвлөлтийн үлгэр жишээ өөрчлөлтийг хийх юм. Хотууд дотроо болон хотын захиргааны нийтийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдтэй харилцан мэдлэг солилцох, суралцах өргөн боломж нээгдэнэ. Ногоон хотууд хөтөлбөр нь хотуудад байгаль орчны гүйцэтгэлд бодитой, эерэг сайжруулалт хийхэд нь шаардагдах арга хэрэгслийг бүрдүүлэн өгч,

уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор хот, суурин газарт улам бүр тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх нэн чухал бөгөөд даяар зохист жишгийг тогтоож өгөх юм.

1.2 Хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрт хамрагдах тухайн бүс нутагт тулгараад буй хэд хэдэн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилготой Ногоон хотууд хөтөлбөр нь дараах зорилтыг хангана. Үүнд:

Зорилт 1. Бодлого, стратегийн дэмжлэг үзүүлэх

Хөтөлбөр хэрэгжүүлэгч хот бүрийг тогтвортой хөгжүүлэх босго, алсын харааг тогтоож, хотын захиргааны удирдлагууд болон гол оролцогч талуудад байгаль орчны тулгамдсан асуудал, сорил бэрхшээлийг шийдвэрлэхдээ уур амьсгалын талаар мэдээлэлжсэн шийдвэр гаргахад нь туслалцаа үзүүлнэ.

- Ногоон хотын үйл ажиллагааг тодорхойлох, босго тогтоох, ажлын чухлын дарааллыг гаргах, үйл ажиллагааг нь удирдан чиглүүлэх ногоон стратегийн баримт бичгийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Тогтвортой хөрөнгө оруулалтыг хангах эрх зүйн орчныг сайжруулахад шаардлагатай хууль, тогтоомжийн нэмэлт өөрчлөлтийг боловсруулна. Жишээ нь засгийн газрын зүгээс төсвийн тухай хууль саад учруулж байна гэж үзсэн тохиолдолд уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад нь засгийн газарт дэмжлэг үзүүлэх, гэх мэт.
- Жендерийн тэгш байдалд бодлогын дэмжлэг үзүүлж, жендерийн тэгш байдлын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд засаг захиргааны байгууллагуудад дэмжлэг үзүүлнэ.

Зорилт 2. Ногоон хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих

- Хотод тулгараад буй агаар, ус, газар/хөрсний чанар, нөөц, ногоон талбайн хүрэлцээ, хүлэмжийн хийн ялгарал зэрэг байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд уян хатан байх зэрэгт оруулах хөрөнгө оруулалтын бие даасан болон хамтарсан санхүүжилтийг хөхиүлэн дэмжинэ.
- Хотын захиргааны үйлчилгээг хүлээн авах болон хэрэглэхэд жендерийн тэгш байдлыг нэмэгдүүлнэ.

Зорилт 3. Хотын захиргаа болон гол оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх

Энэхүү Хөтөлбөр нь зорилтот техникийн туслалцаагаар дамжуулан дотоодын чадавхийг дараах чиглэлд бэхжүүлнэ. Үүнд:

- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, дасан зохицох, нөхөн сэргээх зэрэгт голлон анхаарсан хотын түвшний системтэй, цогц стратеги төлөвлөлт
- Хотын захиргааны түвшинд санхүүгийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах
- Байгаль орчин/нийгмийн хамгааллын бодлогуудын хэрэгжилтийг нэмэгдүүлэх, удирдах
- Олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, нийгэм, эдийн засаг, байгаль орчны дайвар үр шимийг өсгөх

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

- Хөдөлмөр эрхлэх боломжид жендерийн тэгш байдлыг сайжруулах үүднээс хотын захиргаа болон гол оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэх үр нөлөөг үзүүлэх зэрэг болно.

Зорилт 4. Хотуудыг хөрөнгийн зах зээлд оролцох чадавх, боломжоор хангах

- Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс хөрөнгийн зах зээлд оролцоход хотуудад нүүрлэдэг бэрхшээл саадуудыг шийдвэрлэх бодлогын суурийг бэлтгэх
- Хувийн хэвшлийн санхүүжилтийг татах нөхцөл болон процессуудыг бэлэн байлгах үүднээс засаг захиргаа болон оролцогч талуудын чадавхийг бэхжүүлэн сайжруулах

Хөтөлбөр нь эдгээр зорилтыг ханган биеүүлэхийн тулд хотуудын онцгой хэрэгцээ шаардлагыг хангаж, зах зээлийн саад бэрхшээлийг даван туулах стратеги ба бодлогын дэмжлэг, дэд бүтцийн хөрөнгө оруулалт ба чадавхи бэхжүүлэлт болон техникийн туслалцааг хослуулах юм. Түүнчлэн Ногоон хотууд хөтөлбөр нь тогтвортой хөгжлийг хангах хүрээнд тулгараад буй сорил бэрхшээлийг тодорхойлж, дараалалд оруулж, шийдвэрлэх холистик арга хандлагыг хотуудад гаргаж өгөх замаар уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны асуудлуудтай тэмцэх “нийтлэг боловч тохируулан өөрчилсөн” үйл ажиллагааг харуулахыг зорьж байгаа болно.

Тус Хөтөлбөр нь доорх бүрдэл хэсгүүдийг хангах замаар ногоон хотод тулгараад буй зах зээлийн хэд хэдэн саад бэрхшээл, тулгамдсан асуудлыг шийдвэрлэнэ. Эдгээр бүрдэл хэсгүүд нь:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Ногоон хотын ажлын төлөвлөгөө (НХАТ) ба бодлогын хэлэлцүүлэг: Ногоон өсөлтийг хангахыг эрмэлзэхийн сацуу уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой асуудлуудыг шийдвэрлэх хотуудын үйл ажиллагааг тодорхойлох, босго тавих, дараалалд оруулах, чиглүүлэх ногоон стратегийн баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлж, хууль тогтоомж/бодлогын нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах.

Бүрэлдэхүүн хэсэг 2. Ногоон хотын дэд бүтцийн хөрөнгө оруулалт: Олон нийтийн барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлт, ус, бохир ус, нийтийн тээвэр, нийтийн зам, гэрэлтүүлэг, хатуу хог хаягдлын менежмент, дүүргийн халаалтыг шинэчлэх зэрэг тэргүүлэх салбаруудад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах, нөхөн сэргээх, дасан зохицох хөрөнгө оруулалтын бие даасан болон хамтарсан санхүүжилтийг ханган, дэмжих. Хотуудын эдгээр төслүүдэд авах санхүүжилтийг зөвхөн ЕСБХБ-ын санхүүжилтээр хязгаарлахгүй.

Бүрэлдэхүүн хэсэг 3. Техникийн туслалцаа ба мэдлэг чадваржуулалт олгох: Хотын захиргааны түвшинд санхүүгийн болон үйл ажиллагааны гүйцэтгэлийг сайжруулах; уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох эдийн засгийн болон нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг тогтоон удирдах; олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлж, нийгэм, эдийн засгийн болон байгаль орчны дам ашиг тусыг сурталчлах. Тусгайлан зохион байгуулах арга хэмжээнүүд, сургалтууд болон дэлхийн хотуудын сүлжээний оролцоо зэргээр дамжуулан ногоон хотын хөгжлийн зохистой дадлуудыг түгээх.

Бүрэлдэхүүн хэсэг 4. Ногоон хөрөнгийн зах зээлийн замын зураглал:

Ногоон хөрөнгө оруулалтад хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татахад хотуудад шаардагдах хэрэгсэл болон чадавхийг хөгжүүлэх; үүнд ногоон хөрөнгө оруулалттай холбоотойгоор хөрөнгийн зах зээлтэй харилцаа үүсгэх боломжуудыг таних чадавхийг суулгах, ногоон санхүүжилтийн болзол хангах хөрөнгө оруулалтыг танин тодорхойлж, таницуулах, шинэ арга зам, талбаруудаас хөрөнгө эргэлтэнд оруулах зэрэг орно.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

2. Хамрагдах боломж

2.1 Хөтөлбөрт хамрагдах боломжтой зорилтот хотууд болон хот

Хотууд Хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ НХАТ болон гүйцэтгэлийн тодорхой шалгууруудыг хангасан хөрөнгө оруулалтын дэд төслийн (гарааны төсөл гэж нэрлэнэ) хамт ирүүлнэ. Эдгээрийг хамтад нь ирүүлэх нь хүсэлт гаргасан хотуудын Хөтөлбөрт багтах эхлэл болно. Ногоон хотууд хөтөлбөрт доорх шалгуурыг хангасан хотууд болон хөрөнгө оруулалтын төслүүдийг нэмэлтээр оруулж болно.

ЕСБХБ нь Хөтөлбөрт багтах ногоон хотын төсөл бүрт сүүлийн байдлаар хяналт шалгалт хийсний дараа батална. Дэд төсөл тус бүрийн хяналт шалгалтын хүрээнд ЕСБХБ нь хотын захиргаа болон нийтийн аж ахуйн компаниудын төсөл амжилттай хэрэгжүүлэх, үндэсний хууль тогтоомж болон ЕСБХБ, Ногоон уур амьсгал сан (НУАС)-ийн бодлого, журмыг сахин мөрдөх чадамжид үнэлгээ хийнэ. Байгаль орчин, нийгмийн хариуцлагыг ухамсарлан, төслийг ЕСБХБ-ын Гүйцэтгэлийн шаардлагуудад нийцүүлэн хэрэгжүүлэх зээлдэгчийн чадавхийг үнэлэх нь ЕСБХБ-ын Байгаль орчин, нийгмийн үнэлгээний салшгүй хэсэг байна. Үүнд зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн бодлого, менежментийн систем болон нөөцийг Байгаль орчин, нийгмийн менежментийн систем, Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө, Байгууллагын чадавхи, Оролцоо зэргийг тусгасан Гүйцэтгэлийн шалгуур 1-тэй тулган шалгана. Хэрэв хяналт шалгалтаар ЕСБХБ-ын шаардлагуудыг хангаагүй үзүүлэлт илэрвэл байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх арга хэмжээг Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана. Харилцагчид дэмжлэг туслалцаа шаардлагатай болбол ЕСБХБ нь Техникийн хамтын ажиллагааны сангаар дамжуулан чадавхийг бэхжүүлэх Техникийн туслалцаа үзүүлж болно.

Хөтөлбөрийн энэ үе шатанд багадаа 10 хот доорх ажлыг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- Ногоон хотын ажлын төлөвлөгөөг (НХАТ) боловсруулах (Бүрэлдэхүүн хэсэг 1.1);
- Нэг хотод нийтийн ногоон дэд бүтцийн 1-4 төсөлд хөрөнгө оруулах (Бүрэлдэхүүн хэсэг 2);
- Нийтийн ногоон дэд бүтцийг уур амьсгалд хариуцлагатай хандах байдлаар хөгжүүлж, арчилж, ажиллуулах институцийн чадавхийг бүрдүүлэх (Бүрэлдэхүүн хэсэг 3).
- Тохиромжтой нөхцлүүдэд Ногоон хөрөнгө оруулалтыг дэмжих боломжуудыг тодорхойлсноор хөрөнгийн зах зээлтэй харилцааг сайжруулах; (Бүрэлдэхүүн хэсэг 4).

2.2 Хамрагдах боломжтой дэд төсөлд тавигдах гүйцэтгэлийн шаардлага

Хөтөлбөрийн гарааны болон НХАТ гарсны дараах төслүүдийн аль аль нь Банкны Гүйцэтгэлийн шаардлагуудад тодорхойлсон байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг хангасан бүтэц, зохион байгуулалттай байх шаардлагатай сацуу үйл явдлын өмнөх дүн шинжилгээгээр үнэлэгдсэн байгаль орчин, нийгмийн дараах шалгууруудыг хангасан байна.

- Хоттой хийж байгаа хөрөнгө оруулалтын бүх төслүүд нь дараах нөхцөлүүдийг хангасан байх шаардлагатай. Үүнд:
 - i. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах болон дасан зохицох нөлөөлийг нотлох доорх нөхцлүүдээс дор хаяж нэг болон түүнээс дээшийг хангасан байна:
 1. Хүлэмжийн хийн ялгарлыг багадаа 15 хувиар бууруулах;
 2. Эрчим хүчний хэмнэлтийг дор хаяж 15 хувиар нэмэгдүүлэх; эсхүл
 3. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг дараах хэмжүүр, босгоор сайжруулах:

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Хүснэгт 1. Ногоон Хот дэд бүтцийн хөрөнгө оруулалтын дасан зохицох үйл ажиллагааны зохимжтой үзүүлэлтүүд болон босгууд

Уур амьсгалын эрсдэл (нөхцөл байдлаас хамаарна)	Дасан зохицох байдлын хэмжүүр	Нэгж	Сайжруулах босго
Усны стресс нэмэгдэх	Усны хангамжийг нэмэх*	м ³ / жил ¹	10 %
Халууны стресс нэмэгдэх	Эрчим хүчний хангамжийг нэмэх *	кВтц/ жил ²	15 %
Халууны стресс нэмэгдэх <i>эсвэл</i> цаг агаарын гамшигт үзэгдэл нэмэгдэх	Хүн амын эрүүл мэнд болон бүтээмжийн сайжралт*	QALY (чанартай амьдралын жил)	10%
Усны стресс нэмэгдэх <i>эсвэл</i> цаг агаарын гамшигт үзэгдэл нэмэгдэх	Гэмтэл, хор нөлөөг багасгах **	Жилд ногдох өдөр, цаг	10%
Халууны стресс нэмэгдэх <i>эсвэл</i> Усны нөөцийн өөрчлөлт нэмэгдэх <i>эсвэл</i> цаг агаарын гамшигт үзэгдэл нэмэгдэх	Хорт нөлөөг багасгах**	НОЦТОЙ ХОР НӨЛӨӨ: эрсдлийн давтамж (%) УРТ ХУГАЦААНЫ ХОР НӨЛӨӨ: эд зүйлсийн насжилт (жилээр) ³	10% ⁴

* Уур амьсгалын өөрчлөлтөнд өртөмхий байдлын хүрээнд

** Үүнд цаг агаартай холбоотой хор нөлөө, гэмтлийг хэлнэ

¹ Хүлэмжийн хий болон эрчим хүчний хэмнэлтийн хэмжилтүүд нь ЕСБХБ-ны Ногоон Эдийн Засгийн Шилжилтын Гарын Авлагад төслийн байгаль орчны нөлөөллийг хэмжих, тайлагнах талаар заасны дагуу байх юм. Тус гарын авлага нь [ОУ-ын Санхүүгийн Байгууллагын Хүлэмжийн Хийг Тооцолох Нэгдсэн Тогтолцоог](#) хамруулсан болно.

² Усны хэмнэлтийг хэмжихдээ ЕСБХБ-ны Ногоон Эдийн Засгийн Шилжилтийн Гарын Авлагад тодорхойлсон аргачлалыг хэрэглэх болно.

³ ОУ-ын Санхүүгийн Байгууллагын Эрчим Хүчний Хэмнэлттэй Төслүүдийн Хүлэмжийн Хийг Тооцолох Аргачлалаар тодорхойлсон суурь аргачлалыг ашиглан төсөл тус бүрд хийсэн магадлан шинжилгээнд үндэслэнэ

⁴ М Чанартай амьдралын жилүүд, хор нөлөөний жилд тохиолдох өдрүүд болон цагууд ба ноцтой хор нөлөө, урт хугацааны хор нөлөөний хэмжүүрүүд нь тодорхой салбар тус бүрийн зохистой дадлын дүн шинжилгээнд үндэслэх болно.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

- ii. Нийтийн тээвэр, дүүргийн халаалт, ус ба бохир ус, гудамжны гэрэлтүүлэг, хог хаягдлын менежмент, эрчим хүчний хэмнэлттэй холбоотой сайжруулалтууд болон орон сууц, барилгын нэмэлт засварууд зэрэг хотын захиргааны дэд бүтцийн салбарт харъяалагдах ёстой
- iii. Санхүүжилт авсан дасан зохицох үйл ажиллагаа нь ХүХ ялгаруулалтыг нэмэгдүүлэхгүй байх

Түүнчлэн:

- Хотод оруулсан бүх эхний хөрөнгө оруулалт нь (i) НХАТ-ийг НХАТ-ийн аргачлалд тулгуурлан боловсруулж хотын захиргаагаар батлуулж, (ii) НХАТ боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцсан ажилтныг тодорхойлж томилсон байна.
- НХАТ-г боловсруулсны дараах болон гарааны төслүүдийн хэрэгжилтийн дараах бүх хөрөнгө оруулалт нь тухайн хотын НХАТ-ний тэргүүлэх чиглэлд тодорхойлсон байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэнэ. Хот нь хот суурин газрын байгаль орчны гүйцэтгэлийг хэмжих НХАТ-ийн үзүүлэлтүүдээс Байгаль орчны тэргүүлэх чиглэлийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлно.
- Хөтөлбөрийн хүрээнд хийгдэх уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицохтой холбоотой бүх хөрөнгө оруулалт нь уур амьсгалын эрсдэлийн үнэлгээний цогц процессоор боловсруулагдан, үнэлэгдэх болно. Тохиромжтой тохиолдолд энэ үнэлгээг хийхдээ Олон Талт Хамтын Ажиллагааны Хөгжлийн Банкны Уур Амьсгалын Санхүүжилтийн Группийн дасан зохицох санхүүжилтийн урсгалыг хянах гурван шатлалт аргачлал болон Европын санхүүгийн байгууллагуудын уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох ажлын хэсгийн (ЕСБУАӨДЗАХ) уур амьсгалын өөрчлөлттэй дасан зохицох төсөл боловсруулах удирамж зэргийг ашиглах болно. Ингэснээр, санал болгож буй хөрөнгө оруулалтын төсөл тус бүрийн уур амьсгалын мэдрэмтгий буюу эмзэг байдлыг тодорхойлж, бага, дунд эсвэл их гэсэн зэрэгчлэл өгөх болно. Энэ процесс нь тухайн санал болгож буй хөрөнгө оруулалт нь Ногоон Хот хөтөлбөрийн хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох төслийн урьдчилсан шалгууруудыг хангаж байгаа эсэхийг шийдэхэд ашиглагдах болно.

2.3 Дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллүүд, тэдгээрийг бууруулах арга хэмжээ

Хөтөлбөр, ялангуяа Ногоон хотын ажлын төлөвлөгөөний үйл явц нь байгаль орчны стратеги үнэлгээний загварт суурилсан бөгөөд ижил төстэй зорилтуудтай ба үүнээс байгаль орчны тэргүүлэх чиглэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж Хот байгаль орчны зорилтуудад хүрэхэд үр дүнтэйгээр хувь нэмэр болохуйц стратегийн зорилт, тэргүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт бүхий Хотын ногоон алсын хараа болох баримт бичиг бий болох юм. Түүнчлэн НХАТ-ийн үйл явц нь суурь өгөгдлүүдээс эхлээд дэд төслүүдийн байгаль орчин, нийгмийн тодорхой үр шим, эрсдэл, нөлөөлөл, талуудын оролцоо зэргийг хамран тэргүүлэх чиглэлийн үйл ажиллагааг тогтоох хүртэлх үе шатууд бүхий байгаль орчны стратеги үнэлгээний процессийг тусгасан байдаг. Байгаль орчин, нийгмийн асуудлууд, процессийн туршид тэргүүлэх чиглэлийн дэд төслүүдийг сонгоход оролцож буй талуудын оролцоо зэргийг нэгтгэсэн стратегийн энэхүү арга хандлага нь тэргүүлэх чиглэлийн төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлээс зайлсхийх буюу тэдгээрийг бууруулахад ихээхэн үр дүнтэй байдаг. Үүн дээр дэд төсөлд тусгайлан хийгдэх байгаль орчин, нийгмийн үнэлгээ нэмэгдэх ба энэхүү үнэлгээгээр тухайн төслүүдээр ЕСБХБ-ын ГШ-д тодорхойлсон тогтвортой байдлын үр дүнг хангуулах бүтцийн өөрчлөлтийг хийх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг тодорхойлно.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Дэд төслүүд нь гол төлөв нийтийн болон орон сууцны барилга байгууламжийн эрчим хүчний хэмнэлт, цэвэр, бохир ус, нийтийн тээвэр, зам, гэрэлтүүлэг, хатуу хог хаягдлын менежмент, дүүргийн халаалт зэрэг тэргүүлэх чиглэлүүдийг хамарсан байна. Тэргүүлэх чиглэлийн дэд төслүүд нь байгаль орчны гүйцэтгэлийн өндөр шалгуурыг (дээр тодорхойлсон) хангасан, байгаль орчинд дорвитой үр шим өгөхүйц, шинэчлэлт, барилгажилтын ажлуудаар хязгаарлагдах байгаль орчин, нийгмийн хязгаарлагдмал болон түр зуурын эрсдэл, нөлөөллүүдийг хамарсан байна. Төсөл нь одоогийн барилга байгууламжийн сэргээн шинэчлэлт, эсхүл шинэ барилга байгууламжийн бүтээн байгуулалтыг хамарч байгаа эсэхээс шалтгаалан байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөлөл нь харилцан адилгүй шинж чанартай байж болно. Тухайлбал:

- Газар ашиглалтыг өөрчлөх шаардлагагүй, одоогийн барилга байгууламжийг сэргээн шинэчилж, сайжруулахтай холбоотой дэд төслүүдийн хувьд эдгээр эрсдэлүүд нь төлөвлөлтийн бүсийн хэмжээнд байх ба тэдгээрийг олон улсын сайн туршлагыг нэвтрүүлэн мөрдөх замаар төвөггүй бууруулж болно.
- Ус, ариун цэвэр, эсхүл дүүргийн халаалтын шинэ шугам сүлжээ, нийтийн шинэ зам, томоохон хэмжээний ус цэвэршүүлэх байгууламж, дүүргийн дулааны станц, эсхүл хатуу хог хаягдал боловсруулах байгууламж зэргийг шинээр барьж байгуулахтай холбоотой дэд төслүүдийн хувьд хот суурин газрын орчин нөхцөлд ийм төсөл хэрэгжүүлэхээс үүдэн бий болох орон зайн төлөвлөлтийн асуудалд онцгой анхаарал хандуулах шаардлагатай. Ийм төрлийн төслүүдэд байршил, газар ашиглалтыг өөрчлөхтэй холбоотойгоор үүсч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг бууруулж, арилгах үр дүнтэй аргуудыг ашиглах хамгийн тохиромжтой шийдлийг тодорхойлоход талуудыг татан оролцуулах шаардлагатай болдог. Орчны асуудлуудыг тодорхойлж, шийдвэрлэхэд талуудын үр дүнтэй бөгөөд утга учиртай оролцоо голлох үүрэгтэй байдаг.

Аль ч төрлийн төслүүдийн хувьд үйл ажиллагааны төлөвлөгөөг байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэл, нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах тодорхой арга хэмжээг зөвшилцөн боловсруулсан байна.

3. Хот суурин газар, байгаль орчин, нийгмийн хүрээ

3.1 Хот суурин газрын хувьд

Зүүн өмнөд Европын хот суурин газруудад ч мөн ижил асуудал тулгараад байгаа бөгөөд тэдгээрийн дийлэнх нь эрчим хүч ашиглалттай холбоотой байна. Сербийн хотуудад эрчим хүчний үр ашигтай ашиглалтыг хөхиүлэн дэмжих өргөн боломж бий. Ийм боломж үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж, барилга байгууламжийг (ялангуяа улсын) арчилж тордолгүй орхисон, эдийн засгийн болон ашиглалтын хугацаа нь дуусчихсан их хэмжээний тоног төхөөрөмж бүхий ЕСБХБ-ын үйл ажиллагаа явуулдаг өөр бусад улс орнуудад бүр ч илүү өндөр байгаа юм. Эрчим хүчний үнийн өсөлт, үеэ өнгөрөөсөн хуучин, үр ашиггүй тоног төхөөрөмж, хэмжин тооцоолох болон хяналт тавих хэрэгслүүд дутмаг байгаа зэрэг нь болзошгүй эрсдэлийг бий болгож байна. Өнөөгийн эдийн засгийн хямралт нөхцөлд хэдийнэ туйлдаад байгаа бизнесийн байгууллага, барилга байгууламжийн өмчлөгч/захиргаанд эрчим хүчний үнийн өсөлт нэмэлт дарамт учруулж байгаа юм. Ийм сорил бэрхшээлийг шийдвэрлэх үр дүнтэй арга нь эрчим хүчний хэмнэлтийг сайжруулах явдал билээ.

Албанийн хот суурин газруудад ч мөн орон сууцны болон төрийн хэвшлийн барилга байгууламжууд нь үр ашиггүй болсны улмаас эрчим хүчний зардал хэмнэхтэй холбоотой хөрөнгө оруулалтын боломжийг нээсэн ижил сорил бэрхшээлүүд тулгараад байна. Үүнээс гадна Албани улс, түүний хотууд нь усан цахилгаан станц, цахилгааны хэрэглээг хангах импортоос ихээхэн хамааралтай байдаг тул зүүн өмнөд Европын бусад улсуудтай харьцуулахад Албанид

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

цахилгаан тасрах тохиолдол элбэг. Усан цахилгаан станц нь ус судлалын хувьд уур амьсгалын өөрчлөлтөд өртөмхий бөгөөд гадаргын усны урсацыг багасдаг тул нийтээр нь цахилгаанаар хангах асуудалд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох хөрөнгө оруулалтын нэлээд их хэрэгцээ шаардлага нэмэгдэж байна.

ХЮБНУ Македони улсын хувьд агаарын бохирдлын хэмжээ Европын бусад орнуудынхаас нэн өндөрт ордог ба нийтийн эрүүл мэндэд ноцтой нөлөөлдөг. Эрүүл мэндтэй холбоотой асуудлуудын 45 хувь нь зөвхөн Скопье хотод гарч байгаагаас үүнийг тодхон харж болно. Агаарын бохирдлын дийлэнхийг хуучирсан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, үйл ажиллагаа бүхий эрчим хүчний дэд бүтэц, тээвэр үйлдвэрлэж байгаа юм. Тээврийн хэрэгсэл, зам, тээврийн сүлжээний нөхцөл муугаас тээврээс их хэмжээний угаар ялгарч байна. Ялангуяа тархай суурьшилтай, газрыг үр ашиггүй ашигладаг хот суурин газарт хувьдаа машин эзэмшигчдийн тоо нэмэгдэж байна. Хөгжлийн ийм хэв маяг нь усан хангамж, хатуу хог хаягдлын менежмент, эрчим хүчний хангамж тасалдах, бохир ус цэвэршүүлэлт муудах, нийтийн тээврийн хүртээмж хязгаарлагдахад хүргэж байгаа юм.

Молдавт гэхэд орон сууцны барилга байгууламж нь нэн үр ашиггүй ажиллаж байна. Молдавын орон сууцны салбар нь улсынхаа эрчим хүчний хэрэглээний 40 хувийг, зай талбай халаахад орон сууцны эрчим хүчний 70 хувийг хэрэглэдэг хамгийн том эрчим хүч ашиглагч юм. Гэвч Молдавын бүхий л шатанд аж үйлдвэрийн болон орон сууцны салбарт тогтвортой эрчим хүчний төслүүдэд хөрөнгө оруулахад зах зээлийн хаалт саад өндөр хэвээр байна.

Тунисийн хамгийн том цахилгаан хэрэглэгч нь 36 хувийг ашигладаг үйлдвэрлэлийн салбар юм. Эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлэхэд ойлголт мэдээлэлгүй байдал, техникийн хүчин чадал муу, гол оролцогч талуудын (ESCOS, банкууд, үйлдвэрлэгч компаниуд, төрийн байгууллагууд гэх мэт) хоорондын итгэлцэл сул зэрэг хэд хэдэн саад бэрхшээл тулгарсан хэвээр байна. Үүнээс гадна хотын хог хаягдлын 85 хувийг газарт булж устгадаг, 1 хүрэхгүй хувийг нь дахин боловсруулдаг тул Тунис хог хаягдлын менежмент, нөөцийн үр ашигтай ашиглалтаар нэлээд хоцрогдож байна.

Кавказын бүсийн хот суурин газрууд, тухайлбал Армени, Гүрж улсууд хэдэн үе дамжсан хуучин нийтийн тээврийн сүлжээтэй. Трамвай, тролейбус, автобусны замын сүлжээтэй байдаг байсан хотууд өдгөө нийтийн тээврийн шинэ сүлжээг шинэчлэх болон өргөтгөхөд санхүүжилт хийх нь бүү хэл одоогийн тээврийн сүлжээгээ арчилж тордож ч чадахгүй байдалтай байна. 1990-ээд оноос хойш засвар арчилгаа хийгдээгүйгээс бүс нутгийн хэмжээнд нийтийн тээврийн сүлжээ системээ хэсэгчлэн хаахад хүрээд байгаа юм.

Монголын хот суурин газруудад хотын захиргааны хууль тогтоомжийн үйлчлэл сул, хууль сахилтад улс төрийн хөндлөнгийн оролцоо зонхилсон хэвээр байна. Хэмжилт хийх нь ховор, бодит ашиглалтад суурилсан төлбөрийн тогтолцоо бараг байхгүй шахам байгаа нь үр ашигтай ашиглалтыг тийм ч сайн дэмжихгүй байгаа юм. Нийтийн тээврийн үйлчилгээ зохицуулалтгүй, хувийн микро автобусны үйлчилгээ ашигтай бөгөөд зонхилсон байдалтай байна. Гэвч нэлээд нь хуучирч доройтсон тээврийн хэрэгслүүдэд парк шинэчлэлт хийх хүчин чадал нь хязгаарлагдмал. Нэлээд ерөнхий асуудлууд нь үр ашиггүй зардал (ажиллах хүн хүчний удирдлага, хуваарилалт оновчтой бус, эрчим хүчний хэрэглээ өндөр), орлого төвлөрүүлэлт сул (төвлөрүүлэлтийн хувь хэмжээ бага), усны чанар муу, усны алдагдал их зэрэг болно.

Иорданы хувьд хүн амын 83 хувь нь хот суурин газарт оршин суудаг. Энэ нь Хөтөлбөрт хамрагдаж буй улсуудынхаас хамгийн өндөр хувь хэмжээ юм. Иордан нь дэлхийн усны хүртээмж, хүрэлцээ хамгийн багатай орнуудын нэг бөгөөд хот суурин газруудынх нь усны

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

дэд бүтэц нэлээд сул. Шугамын цоорол, хэмжилтийн систем хангалтгүйгээс ус ханган нийлүүлэх шугам сүлжээ нь дунджаар 68 хувийн усны алдагдалтай ажилладаг. Усны төлбөр нь зах зээл дээрх үнэтэй харьцуулахад маш бага байдаг тул усны шугам сүлжээг арчилж, тордох үүрэгтэй эрх бүхий байгууллага нь зардлаа нөхөх механизмгүй байна.

3.2 Байгаль орчин, нийгмийн хүрээ

Хөтөлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүд нь Хөтөлбөрт хамрагдах бүс нутгийн байгаль орчин, нийгмийн тулгамдсан асуудлуудад шууд чиглэнэ. Хөтөлбөрт хамрагдах бүс нутаг нь эрчим хүчний ашиглалт үр ашиггүй, агаарын бохирдол, нүүрстөрөгчийн нягтрал өндөртэй (тСО2эк/ДНБ), зарим орнуудын нүүрстөрөгчийн ялгарал, нягтрал нь дэлхийн дунджаас 8 дахин их гэх мэт байгаль орчны хурцадмал асуудалтай бүс нутгууд байна. Эрчим хүчний үр ашиггүй ашиглалт нь хот суурин газрын төрийн болон хувийн хэвшлийн аль алиных нь барилга байгууламжийн эрчим хүчний гүйцэтгэлийн түвшин муу байгаагаас тод харагдана.

Хог булсан талбайгаас шүүрэх метанаас хүлэмжийн хий ялгархад хүргэж буй хог хаягдлын менежментийн асуудал нь бас нэгэн зонхилох асуудал мөн. ЕСБХБ-ын бүс нутгийн ихэнх хотуудын жилд нэг хүнд ногдох хотын хог хаягдлын хэмжээ ЕХ-ын дунджаас их байна. Жишээ нь Гүржид л гэхэд ЕХ-ын дунджаас хоёр дахин их байгаа юм. Эдгээр хог хаягдлыг “хотын нийтийн үйлчилгээний компаниудын (гэрээт гүйцэтгэгч) хогоо асгаж овоолох эсхүл зүгээр л хаяж хадгалдаг талбайд” гол төлөв хаях буюу газарт булдаг. Үүнээс гадна Хөтөлбөрт хамрагдсан бүс нутгуудын хот суурин газрын хог дахин боловсруулалтыг ЕХ-ын дундаж 39 хувь болон ЕХ-ын 2020 он гэхэд хотын хатуу хог хаягдлын 50 хувийг дахин боловсруулах зорилттой харьцуулах ч аргагүй байна.

Мөн бүсийн зарим хотуудын оршин суугчид бусад оршин суугчидтай харьцуулахад маш их хэмжээний агаарын бохирдолд өртдөг байна. Дэлхийн банкныхаар (2015) бол Иорданы хот суурин газрын оршин суугчид бүхэлдээ буюу 100 хувь аюулт барамнас (нарийн ширхэгт тоосонцор) бодис (PM2.5)-т хордож байгаа ба энэ хэмжээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон дэлхийн дундаж болох 92 хувиас их байгаа юм.

Хөтөлбөрийн бүсийн хот суурин газрын дэд бүтэц муудаж доройтсон буюу хэрэглээнээс гарсан байгаа нь амьдралын чанарыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлт бий болох шалтгааныг хүндрүүлж, олон нийтийн дасан зохицох болон уян хатан байх чадварыг сулруулж байна. Энэ дундаас ногоон хотын төлөвлөлт, дэд бүтцийн хөрөнгө оруулалтад саад учруулж буй хэд хэдэн зүйл байна. Үүнд:

- iv. Хот төлөвлөлтөд уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх системтэй, цогц арга хандлагыг тусгаагүй. Хэдийгээр улс орнуудын засгийн газар хот суурин газрын тогтвортой байдлын асуудлыг шийдвэрлэхийг эрэлхийлэн оролцож байсан ч хотын захиргааны хэрэгцээ шаардлагаас хамааран эдгээр хүчин чармайлт нь богино хугацаанд үйчлэх хандлагатай байв. Тиймээс хот суурин газрын тогтвортой байдлын нарийн төвөгтэй асуудлыг шийдвэрлэхэд ногоон хотыг хөгжүүлэх системчилсэн, цогц арга хандлагыг тусган нэвтрүүлэх шаардлагатай юм.
- v. Хууль эрх зүйн саад гэдэгт ногоон үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хэрэгцээ шаардлагад түлхэц өгөх бодлогын дэмжлэг буюу хотын түвшний арга хэрэгсэл дутмаг, эрчим хүчний тариф бага зэрэг багтана.
- vi. Санхүүгийн саад гэдэгт санхүүжилт авах боломж дутагдалтай, хөрөнгө оруулалтыг урамшуулах хангалттай үнэ тогтоолт байхгүй (хүүгийн хувь хэмжээ, зээлийн хугацаа), иргэдийн худалдан авах чадвар, концессийн бус өр төлбөрийг хязгаарласан ОУВС-ийн нөхцөлүүд, өндөр гүйцэтгэлтэй технологийн урьдчилгаа төлбөр өндөр, техник, эдийн

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

засгийн үнэдэслэлийн судалгаа болон эрчим хүчний аудит хийх төсөв хүрэлцээгүй гэх мэт багтана.

- vii. Техникийн саад, ялангуяа ногоон дэд бүтцийн хөрөнгө оруулалтын боломжуудыг үнэлэх ур чадвар, туршлага, техникийн нөү-хау, хүний нөөц, институцийн дорвитой бүтэц зэрэг хотын захиргааны чадавхи сул байдал.
- viii. Дотоодын оролцогч талуудын ногоон хотын арга хандлагын үр ашиг, түүний нийгэм, эдийн засаг, байгаль орчны дагалдах үр шимийн талаар ойлголтгүй байгаа байдал
- ix. Иргэний нийгмийн байгууллагуудын (ИНБ) хооронд идэвхтэн дэмжигч/хотын хүн амд үр дүнтэйгээр хүрч ажиллах, олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог дэмжих, зан төлөвийн зэрэг өөрчлөлтийг бий болгох зэрэгт үр дүнтэй харилцах/туршлага, ур чадвар солилцох чадавхи сул байдал
- x. Дэд бүтцэд оруулах хөрөнгийн хүртээмжгүй байдал. Хотууд олон хүчин зүйлсийн улмаас дэд бүтцийн төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгө татахад, тэр тусмаа хувийн хэвшлээс, хүндрэлтэй байдаг. Эдгээр хүчин зүйлсд: хөрөнгийн анхны өртөг өндөр байх, бусад салбартай харьцуулахад хөрөнгө оруулалтын буцаан төлбөрийн хугацаа илүү удаан байх, хотууд зээлжилтийн зэрэглэлгүй байх болон дотоодын хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байх зэрэг ордог.

4. Байгаль орчин, нийгмийн менежментийн систем (БОНМС)

ЕСБХБ нь Хөтөлбөрт өөрийн Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын (БОНТБХ) цогц хүрээг нэвтрүүлэн ашиглана. ЕСБХБ-ын БОНТБХ нь ЕСБХБ-ыг үүсгэн байгуулах гэрээний Зүйлд заасан байгаль орчин, тогтвортой байдлын суурь үзүүлэлт, Байгаль орчин нийгмийн бодлого (БОНБ) болон үеэс үед шинэчлэгдэх Гүйцэтгэлийн Шаардлагуудад тулгуурласан бөгөөд үүний хэрэгжилтийг Байгаль орчин, тогтвортой байдлын газар (БОТБГ), байгаль орчин, нийгэм, жөндөртэй холбоотой боломжуудыг системтэйгээр тодорхойлох үүргийг Жэндер, эрчим хүчний үр ашиг, уур амьсгалын өөрчлөлтийн (ЭХҮАҮАӨ) багууд гүйцэтгэнэ. ЕСБХБ-ийг 2015 оны 9 дүгээр сард НУАС-аас итгэмжилсэн болно. ЕСБХБ-ын ТУЗ 2014 оны 5 дугаар сарын 7-нд БОНБ, түүний Гүйцэтгэлийн Шаардлагуудын сүүлийн үеийн шинэчлэгдсэн хувилбарыг батласан. Өмнөх 2008 оны БОНБ-ыг хэрэгжүүлэх явцад үүссэн асуудлуудыг шийдвэрлэх, үүсэн бий болж буй тогтвортой байдлын хэд хэдэн асуудлыг хүлээн зөвшөөрөх үүднээс БОНБ-ыг ОУСК, Экуадор банк зэрэг олон улсын санхүүгийн байгууллагуудын бодлоготой нийцүүлэн шинэчлэн найруулсан. БОНБ-ыг иргэний нийгмийн байгууллагууд, үйлдвэрлэлийн холбоод, зээлдэгч, санхүүгийн бусад байгууллагууд болон олон улсын санхүүгийн байгууллагууд зэрэг оролцогч талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр шинэчлэн засварласан болно. БОНМС нь төслийг БОНБ-ын хүрээнд нийцүүлэн боловсруулж, хянах Банкны ажилтнуудын үйл ажиллагааг тоймлосон бөгөөд 2015 онд шинэчлэгдсэн Байгаль орчин, нийгмийн зарчмуудад <http://www.ECBXB.com/what-we-do/strategies-and-policies/environmental-procedures.pdf> илүү дэлгэрэнгүй тусгасан.

ЕСБХБ-ын БОНТБХ-ийн дагуу ЕСБХБ-аас санхүүжүүлж болох эсэхийг шийдвэрлэхэд тус дөхөм болох үүднээс, мөн санхүүжилт хийгдэх тохиолдолд төслийн төлөвлөлт, хэрэгжилт, үйл ажиллагааны явцад байгаль орчин, нийгмийн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор бүх төсөлд байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийдэг. Үнэлгээ нь байгаль орчин, нийгмийн боломжуудыг ч мөн тодорхойлдог. ЕСБХБ нь БОНТБХ, байгаль орчин, нийгмийн үнэлгээ болон мониторингийн бодлогын хүрээнд тухайн төслүүдийг холбогдох хууль, журам болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн боловсруулж, хэрэгжүүлэх нөхцөлийг хангахын төлөө ажиллана.

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих бүх төслүүдийг ЕСБХБ-ын Гүйцэтгэлийн шаардлагад нийцүүлэн ангилж, зохион байгуулалтад оруулна. Эдгээрийг доор тоймлон үзүүлэв. ЕСБХБ болон Төслийг дэмжих үйл ажиллагааг хэрэгжүүлэх техникийн зөвлөхүүд нь доор тоймлон тодорхойлсон цогц мониторингийг хийж гүйцэтгэнэ. Энэхүү мониторингийн үр дүнг НУАС-д тайлагнана.

5. Гүйцэтгэлийн Шаардлагууд, хориглох үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөх

Ерөнхий

Банкнаас санхүүжүүлэх төслүүд нь байгаль орчин, нийгмийн тогтвортой хөгжилд хамааралтай олон улсын сайн туршлагад нийцсэн байх шаардлагатай. Зээлдэгчид болон/эсхүл төслүүд энэхүү нөхцлийг хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор ЕСБХБ-аас байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлын гол чиглэлээр Гүйцэтгэлийн тусгай шаардлагуудыг боловсруулсан болно. ЕСБХБ нь ОУСК-ийн 2012 оны Гүйцэтгэлийн стандартын бүтэц, арга хандлага, түүнд хамрагдсан асуудлуудыг багтаасан, уг стандартад нийцсэн арван ГШ-ыг батласан ба төслүүдээс ЕХ-ын байгаль орчны стандартыг хангахыг тусгайлан шаарддаг болно.

Гүйцэтгэлийн тусгай шаардлагууд

ЕСБХБ Гүйцэтгэлийн арван шаардлагууд нь:

- ГШ 1 – Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлын үнэлгээ ба менежмент
- ГШ 2 – Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл
- ГШ 3 – Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хянах
- ГШ 4 – Эрүүл мэнд ба аюулгүй ажиллагаа
- ГШ 5 – Газар чөлөөлөх, албадан нүүлгэн суурьшуулах ба эдийн засгийн хохирол амсах

ГШ 5 нь газар эзэмшилт, газар ашиглалтыг өөрчилснөөс үүдэн биет нүүлгэн шилжүүлэлт явуулах (өөр газар луу нүүлгэх эсхүл орон байраа алдах) болон эдийн засгийн хохирол амсах (эд хөрөнгө, нөөц боломжоо алдах ба/буюу эд хөрөнгө буюу нөөц боломжийг ашиглах боломжгүй болсноор орлогын буюу амьжиргааны эх үүсвэрээ алдах) зэргийг багтаасан ЕСБХБ-ын бүх төслүүдэд мөрдөгдөх Нүүлгэн шилжүүлэлтийн зарчмууд (НШЗ) болон тухайн улсын хууль тогтоомж, дүрэм журмыг тогтооно. ГШ 5-д тодорхойлсон НШЗ нь дараах зорилготой. Үүнд:

- төслийг хэрэгжүүлэх өөр хувилбаруудыг судлах замаар албадан нүүлгэн суурьшуулалтаас зайлсхийх, гарцаагүй тохиолдолд багасгах,
- нөлөөлөлд өртсөн хүн амын газар ашиглах эрхийн хязгаарлалт, эсвэл газар чөлөөлөлтөөс үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг (i) алдсан эд хөрөнгөө дахин шинээр бий болгоход шаардагдах зардлыг нөхөн олгох, (ii) нүүлгэн суурьшуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ мэдээллийг ил тод байлгах, зөвлөлдөх, нөлөөлөлд өртсөн хүн амыг мэдээллээр ханган оролцуулах замаар бууруулна.
- нөлөөлөлд өртсөн хүн амын амьдралын стандарт болон амьжиргааны түвшинг нүүлгэн шилжүүлэлтийн өмнөх түвшинд аваачих, боломжтой бол сайжруулах,
- нүүн очсон газар нутагт газар эзэмших баталгаат эрх, тохирсон орон байраар хангах замаар биет нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүн амын амьдралын нөхцлийг сайжруулах асуудлууд болно.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

НШЗ-д хяналтын шалгуур үзүүлэлтүүд, хамрагдах боломжийн шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээ ба хэрэгжилтийн зарчим, тусгайлан зөвлөлдөх шаардлагууд, институцийн зохион байгуулалт, үнэлгээний аргачлал, ерөнхий нөхөн олговрын матриц, гомдол ба мониторингийн механизм, төсөвлөсөн төсөв, чадавхийг бэхжүүлэх төлөвлөгөө (шаардлагатай бол) багтана. Түүнчлэн НШЗ нь нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө боловсруулахад тавигдах шаардлага, журмыг багтаана.

- ГШ 6 – Биологийн олон янз байдлыг хадгалах, байгалийн амьд нөөцийг тогтвортой ашиглах
- ГШ 7 – Нутгийн уугуул иргэд

Хөтөлбөр хэрэгжих бүсэд нутгийн уугуул иргэд байхгүй тул Нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй.

- ГШ8–Соёлын өв
- ГШ 9 – Санхүүгийн зуучлагчид
- ГШ 10 – Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо

ГШ бүр нь зорилго хэсэгтээ хүрэх үр дүнг тоймлосон бөгөөд эдгээр үр дүнд хүрэхэд зээлдэгчид тус дөхөм болох үүднээс төсөлд тавигдах тусгай шаардлагуудыг мөн багтаасан болно. Холбогдох үндэсний хэмжээний хуул тогтоомжийг дагаж мөрдөх нь бүх ГШ-ын салшгүй хэсэг байна.

ГШ-ыг бүрэн эхээр нь [энэ холбоосоор орж](#) харна уу.

6. Ангилал

Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжих дэд төсөл бүрт байгаль орчин, нийгмийн хяналт шалгалт хийж, байгаль орчин, нийгмийн хянан шалгалтын мөн чанар, түвшин, мэдээллийн ил тод байдал, шаардлагатай талуудын оролцоог тодорхойлох үүднээс төслийн эхний шатанд А, В, С ангиллаар төслүүдийг ангилна. Төслийн ангиллыг төслийн мөн чанар, байршил, мэдрэмтгий байдал, хэмжээ, ирээдүйд байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн далайцыг нь харгалзан хийнэ. Төслийг ангилалд хамааруулсан тухай үндэслэл болон үнэлэлт дүгнэлтийг баримтжуулна. Төсөлд хяналт шалгалт хийж, ангилалд оруулахад шаардлагатай мэдээлэл хангалтгүй байх тохиолдолд хяналт дүгнэлтэд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх, байгаль орчин, нийгмийн хяналт шалгалт, мэдээллийн ил тод байдал, шаардлагатай талуудын оролцооны тохирох ангилал, хамрах хүрээг тодорхойлоход дөхөм болох үүднээс төслийн мөн чанар, байршил, мэдрэмтгий байдал, хэмжээ, ирээдүйд байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн далайцын талаарх мэдээллийг хангалттай хэмжээнд цуглуулах Байгаль орчин, нийгмийн эхний шалгалтыг хийнэ.

Төслийг дараах байдлаар ангилна. Үүнд:

- “А” ангилал. Төслийг ангилах үед тодорхойлох буюу үнэлэх боломжгүй байсан бөгөөд албан ёсны болон оролцооны байгаль орчин, нийгмийн үнэлгээний үйл ажиллагаа хийх шаардлагатай, ирээдүйд байгаль орчин ба/буюу нийгэмд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслүүд. А ангиллын төслүүдийг илэрхийлэх жагсаалтыг БОНБ-ын Хавсралт 2-т үзүүлсэн болно.
- “В” ангилал. Төслийн ирээдүйд байгаль орчин ба/буюу нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл нь төслийн бүсэд илэрсэн ба/буюу нөлөөллийг бууруулах арга хэмжээгээр тодорхойлж, шийдвэрлэж болохуйц төслүүд. Байгаль орчин, нийгмийн үнэлгээнд тавигдах

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

шаардлага нь тухайн төслөөс хамаарч харилцан адилгүй байх ба үүнийг ЕСБХБ тохиолдол тус бүрээр тодорхойлно.

- “С” ангилал. Төсөл нь ирээдүйд байгаль орчин ба/буюу нийгэмд сөрөг нөлөө маш бага үзүүлж болзошгүй буюу огт үзүүлэхгүй бөгөөд байгаль орчин, нийгмийн хязгаарлагдмал үнэлгээгээр шийдвэрлэх боломжтой төслүүд.

Түүнчлэн хөрөнгийг санхүүгийн зуучлалаар (СЗ) дамжуулан оруулах санхүүжилтийн бүтэцтэй төслийг “СЗ” ангилалд хамааруулах ба энэ тохиолдолд СЗ нь дэд төслийн үнэлгээ, мониторингийг хийж гүйцэтгэнэ.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

А ангиллын төслүүд

Ногоон хотууд хөтөлбөрийн хүрээнд А ангилаллын төслүүдэд: шатаах, химийн үйлчилгээ эсвэл аюултай, хортой, хор хөнөөлтэй хог хаягдлыг шатаах, химийн боловсруулалт хийх, хог хаягдлыг булж устгах байгууламжууд; хор хөнөөлгүй хог хаягдлыг шатаах, химийн боловсруулалт хийх томоохон байгууламжууд; 150,000-аас дээш хүн амтай хот суурин газарт зориулсан бохир ус цэвэрлэх байгууламж; хотын хатуу хог боловсруулж устгах байгууламжууд багтана. НУАС-д “зуучлагчийн одоогийн эсхүл санал болгосон хөрөнгөд байгаль орчин, нийгэмд сөрөг эрсдэл, нөлөөлөл үзүүлж болзошгүй олон төрлийн, үл сэргээгдэх эсхүл урьд хожид болж байгаагүй үйл ажиллагааг санхүүжүүлэх хөрөнгө багтсан эсхүл багтах гэж буй” бол тийм үйл ажиллагааг I1 ангилалд хамааруулна.

А эсхүл I1 ангилалд багтах дэд төслүүд нь ЕСБХБ болон НУАС-ийн зөвлөлийн олон тулгуурт зөвшөөрлийн процессоор дамжин батлагдана. ЕСБХБ-ын Гүйцэтгэлийн шалгуурууд, олон нийтэд мэдээлэхтэй холбоотой дор дурдсан шаардлагуудыг хангаж, төслийн байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэлүүдийг зохистой тодорхойлж, бууруулж, шийдвэрлэсэн Ногоон хотууд хөтөлбөрийн хүрээнд багтах А ангиллын дэд төслүүд нь БОННУ-ийн баримт бичгүүдийг боловсруулсны дараа ЕСБХБ-ын ТУЗ-өөс зөвшөөрөл авна. Ингэснээр А ангиллын бүх дэд төслүүд НУАС-ийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, талуудын оролцоо, мэдээллийг нийтэд ил болгох шаардлагуудыг мөн хангах юм.

В ба С ангиллын төслүүд

ЕСБХБ нь В ба С ангиллын төслүүдэд НУАС-аас зөвшөөрөл авна. Ийм ангиллын төслүүдэд НУАС-ийн Зөвлөлийн үнэлгээ, зөвшөөрөл шаардагдахгүй ба ЕСБХБ-ын тогтсон процессын дагуу зөвшөөрөл нь шийдвэрлэгдэж, Банкны Байгаль орчин, нийгмийн тогтвортой байдлыг хангах хүрээний дагуу хэрэгжинэ. Төслүүд нь Банкны Гүйцэтгэлийн шаардлагууд болон дор дэлгэрүүлэн өгүүлэх нийтэд мэдээлэх шаардлагыг хангасан байх шаардлагатай.

7. Байгаль орчин, нийгмийн үнэлгээ

7.1 Байгаль орчин, нийгмийн үнэлгээний цар хүрээ, агуулгыг тодорхойлох

ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээнд (i) төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлууд, (ii) төслийг ГШ-тай нийцүүлэн гүйцэтгэх зээлдэгчийн чадавхи, үүрэг хариуцлага, (iii) боломжтой түвшинд төсөлтэй хамааралтай боловч ЕСБХБ-аас санхүүжүүлээгүй барилга байгууламж, үйл ажиллагаа гэсэн 3 үндсэн асуудлыг тусгана. ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн үнэлгээний цар хүрээг ЕСБХБ-ын Байгаль орчин, тогтвортой байдлын газар (БОТБГ) тухай бүр дээр дурдсан хянан шалгалт, ангиллын дагуу тодорхойлно. Байгаль орчин, нийгмийн хяналт шалгалтын (БОНХШ) хамрах хүрээ, агуулгын хувьд мэдээллийг нийтэд ил болгох болон талуудын оролцоог хангах шаардлагууд нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн болзошгүй эрсдэлүүд, асуудлууд болон нөлөөллүүдэд ижил байна. Төвөгтэй буюу эрсдэл өндөртэй байгаль орчны ба/буюу нийгмийн төслүүдэд БОТБГ-ын зүгээс албан ёсны БОНХШ-ын төлөвлөгөө болон Ажлын даалгавар (АД) боловсруулахыг шаардаж болно.

А ангиллын төслүүдэд Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (БОННУ) хийлгэх шаардлагатай ба үнэлгээнд олон нийтэд мэдээлэх болон зөвлөлдөх үйл ажиллагааг албан ёсоор багтаасан байна. БОННУ-г хийхдээ төсөлтэй холбогдон гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн нөлөөллийг илрүүлэх үе шатыг тодорхойлно. БОННУ-нд эдгээр нөлөөллийн эх сурвалжийг бууруулж болох техникийн болоод санхүүгийн хувьд боломжтой арга хувилбарууд,

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

түүний дотор төслийг хэрэгжүүлэхгүй байх хувилбарыг судалж, авч болох тодорхой арга хэмжээний саналыг баримтжуулсан байна. Мөн нөхцөл байдлыг сайжруулах боломжуудыг тодорхойлж, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд нөлөөллийг багасгах, бууруулах арга хэмжээнүүдийг санал болгоно. БОННУ-ийг бие даасан мэргэжилтнүүдээр хийлгэх буюу шалгуулах шаардлагатай байж болно. БОННУ-ийн үр дүнд Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (БОНМТ), Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө (ТТОТ), мөн шаардлагатай бол Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, Төрөл зүйлийн менежментийн төлөвлөгөө буюу Соёлын өвийн менежментийн төлөвлөгөө, өөр бусад менежментийн тухайлсан төлөвлөгөөг боловсруулан гаргана.

В ангиллын төслүүдийн хувьд төслийн мөн чанар, цар хүрээ, байршилтай уялдсан, үүсэж болзошгүй нөлөөлөл, эрсдэлийг тооцон үзсэн байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийлгэнэ. Үнэлгээгээр төсөлтэй холбоотой цаашид үүсэж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, нөхцөл байдлыг сайжруулах боломжуудыг илрүүлэн, нөлөөллөөс зайлсхийх, зайлсхийх боломжгүй тохиолдолд багасгах, бууруулах арга хэмжээг зөвлөмж болгоно.

Одоо байгаа барилга, байгууламжтай холбоотой (А ба В ангиллын) төслүүдийн хувьд өмнө нь явагдсан болон одоо явагдаж буй үйл ажиллагаанаас үүсэх нөлөөллийг тодорхойлох байгаль орчин, нийгмийн үнэлгээг хийлгэх шаардлагатай. Тус үнэлгээний зорилго нь одоогийн байгаа барилга, байгууламж болон үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй эрсдэл, үүрэг хариуцлага, боломжуудыг илрүүлж, тухайн төслийн үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх, зээлдэгчийн менежментийн систем, нийтлэг үйл ажиллагаа нь эдгээр ГШ-ыг хангаж байгаа эсэхэд үнэлгээ өгөх явдал юм. Одоогийн барилга байгууламжуудыг тухайн объектуудад хамааралгүй бие даасан мэргэжилтнээр шалгуулах нь зүйтэй.

7.2 Одоогийн мэдээллийг хянан судлах

БОНХШ нь төсөлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн хүрэлцээтэй байгаа мэдээллийг тодорхойлж, тэдгээрийг судлахаас эхэлнэ. Ийм мэдээллийг Үйл ажиллагааны баг ба/буюу БОТБГ зээлдэгчтэй хамтран тодорхойлно.

7.3 Төслийн бүсэд ажиллах

Төслийн мөн чанар, зээлдэгчээс авсан мэдээлэлд тулгуурлан БОТБГ нь БОНХШ-ийн хамрах хүрээ, агуулгыг тодорхойлох үүднээс хяналт шалгалтын эхний шатанд төслийн талбайд очиж ажиллах шаардлагатай болж болно. Ингэж газар дээр нь очиж ажиллах бол тодорхой зорилтуудыг тодорхойлсон байна.

7.4 Байгаль орчин, нийгмийн үнэлгээний тайланг хүлээлцэх

Зээлдэгч нь байгаль орчин, нийгмийн үнэлгээг ГШ-д нийцүүлэн гүйцэтгүүлж, байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийхэд шаардлагатай хангалттай мэдээллийг Банкинд гарган өгөх үүрэгтэй. БОТБГ нь энэхүү ажлыг гүйцэтгэхэд нь зээлдэгчид тулалцаа үзүүлж, ГШ-ыг хангахад шаардлагатай хяналт шалгалтын судалгааны хамрах хүрээ, агуулгын тал дээр зөвлөгөө өгөх үүргийг гүйцэтгэнэ.

Байгаль орчин, нийгмийн үнэлгээг хараат бус зөвлөхүүд эсхүл өөр бусад гуравдагч талын мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлнэ. Зарим тохиолдолд төсөл эсхүл зээлдэгч нь өөрийн мэргэшсэн ажилтан эсхүл зөвлөхүүдээр шаардлагатай ажлыг хийлгэж болно. Онцгой

тохиолдолд Банк нь төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээг өөрийн байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүдээр дотооддоо хийлгэхэд тохиромжтой эсэхийг шийдвэрлэнэ.

8. Байгаль орчин, нийгмийн менежмент ба ажлын төлөвлөгөө

Байгаль орчин, нийгмийн үнэлгээгээр тодорхойлсон асуудлууд, талуудын оролцооны үр дүнг харгалзан, зээлдэгч нь ГШ-ыг хангах зорилгоор төслийн нийгэм, байгаль орчны нөлөөлөл, асуудлуудыг шийдвэрлэх, гүйцэтгэлийг сайжруулах арга хэмжээний хөтөлбөр боловсруулж ажиллана.

Тухайн төслөөс хамааран, энэхүү хөтөлбөр нь байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнүүд (БОНМТ) хэмээн нийтэд нь нэрлэгдэх үйл ажиллагааны бодлого, менежментийн систем, холбогдох журмууд, төлөвлөгөө, туршлага, үндсэн хөрөнгө оруулалт зэрэг бодлогын баримт бичгүүдээс бүрдэж болно. Ийм төлөвлөгөө эсхүл хөтөлбөрийн бүрэлдэхүүнд жишээ нь Төрөл зүйлийн менежментийн төлөвлөгөө, Онцгой байдалд авах арга хэмжээний төлөвлөгөө, Нүүлгэн шилжүүлэлтийн төлөвлөгөө, Амьжиргааг сэргээх төлөвлөгөө, Нутгийн уугуул иргэдийг хөгжүүлэх төлөвлөгөө, Хүний эрхийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Талуудын оролцооны төлөвлөгөө ба/буюу өөр бусад тухайлсан төлөвлөгөө багтана.

Төсөл нь тогтоосон ГШ-ыг хангаагүй тохиолдолд зээлдэгч болон Банк нь БОНМТ-өөс гадна ЕСБХБ-д хүлээн зөвшөөрөгдөхүйц хугацааны дотор техник, санхүүгийн хувьд боломжтой, зардалд хэмнэлттэй байдлаар ГШ-ыг хангах арга хэмжээг тодорхойлсон БОНАТ-ийг зөвшилцонө. БОНАТ нь ГШ-ыг хангах төслийн бүтцийн гол хэрэгсэл төдийгүй ЕСБХБ-аас төслийн байгаль орчин, нийгмийн цаг үеийн гүйцэтгэлийг хянах мониторингийн гол хэрэгсэл болдог. БОНАТ-д зээлдэгчийн байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг удирдах ба/буюу төсөлтэй холбоотой боловч төслийн нэг хэсэг нь биш бусад үйл ажиллагааг ГШ-тай уялдуулан сайжруулах арга хэмжээг багтааж болно (БОНБ-ын 37, ГШ 1-ийн 17-20-ийг хар).

Хэрэв байгаль орчин, нийгмийн үнэлгээнд засч залруулах ямарваа арга хэмжээг тодорхойлоогүй бол БОНАТ шаардлагагүй.

9. Байгаль орчин, нийгмийн шаардлагуудыг хангах зэрэг, хариуцлага

9.1 ЕСБХБ-ын зээлдэгчийн үүрэг, хариуцлага

Зээлдэгчид нь тодорхой хугацааны туршид төслүүдтэй холбоотой байгаль орчин, нийгмийн асуудлуудыг Банкны ГШ-д нийцүүлэн зохицуулах шаардлагатай. Шинэ объект, эсвэл шинэ бизнесийн үйл ажиллагаанд холбогдолтой төслүүд ГШ-ыг эхнээсээ хангасан байхаар төлөвлөгдсөн байх хэрэгтэй. Хэрэв одоо байгаа объект, үйл ажиллагаатай холбоотой төслүүд нь Зөвлөлийн хурлаар батлагдах үедээ ГШ-ыг хангахгүй байгаа бол ЕСБХБ-ын хүлээн авахуйц хугацааны дотор ЕСБХБ-ны шаардлагад нийцсэн техникийн болон санхүүгийн хувьд биелэгдэх боломжтой, зардал багатай арга хэмжээнүүд авч, ГШ-д нийцүүлэхийг Банк зээлдэгчээс шаардана. Түүний дээр, ЕСБХБ тухайн төслийн нэг хэсэг биш боловч түүнд хамааралтай үйл ажиллагаандаа ГШ-тай нийцсэн байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагыг хангах талаар зээлдэгчтэй хамтран ажиллана.

Зээлдэгч нь Банкны зүгээс БОНБ-ын дагуу байгаль орчин, нийгмийн үнэлгээ хийхэд шаардагдах хангалттай мэдээллийг өгөх үүргийг хүлээх ба өөрийн зардлаар байгаль орчин, нийгмийн

тохирох судалгааг хийлгэж, талуудын оролцоог хангана. Түүнчлэн зээлдэгч нь ЕСБХБ-ын төлөөлөгч, бие даасан зөвлөхүүдэд төслийн байгууламж, баримт бичгийн бүртгэлд нэвтрэх эрх олгоно. Зээлдэгч нь Байгаль орчин, нийгмийн ажлын төлөвлөгөө (БОНАТ) болон Төслийн хураангуй баримт бичгийн (ТХББ) байгаль орчин, нийгмийн агуулга дээр зөвшилцөх үүрэгтэй байна.

9.2. ЕСБХБ-ын үүрэг, хариуцлага

ЕСБХБ нь Банкны удирдлага, Захирлуудын зөвлөл, эрх бүхий бусад удирдлагын гаргасан шийдвэрийн дагуу Банкны нөөц хөрөнгөөс олон улсын санхүүгийн байгууллагын хувиар төслүүдэд санхүүжилт олгох үүрэг, хариуцлагыг хүлээдэг. Аливаа тодорхой хөрөнгө оруулалт, эсвэл техникийн хамтын ажиллагааны төсөл дэх ЕСБХБ-ын оролцооны түвшин нь төслийн мөн чанар, хэмжээ, хандивлагчийн санхүүжилт байгаа эсэхээр, мөн зээлдэгчтэй тогтоосон хамтын ажиллагаа, харилцааны онцгой нөхцөл байдлаар тодорхойлогддог.

ЕСБХБ нь байгаль орчны болон нийгмийн үндэслэлээр аливаа төслийг санхүүжүүлэхээс татгалзаж болно. ЕСБХБ нь албадан гаргах үйл ажиллагаа явуулж болзошгүй төслүүдийг зориудаар санхүүжүүлдэггүй ба энэхүү бодлогын баримт бичгийн Хавсралт 1-д заасан ЕСБХБ-ны Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалтад багтсан хэд хэдэн төрлийн үйл ажиллагааг санхүүжүүлдэггүй болно.

10. Талуудын оролцоо

ЕСБХБ нь зээлдэгч, зээлдэгч байгууллагын ажиллагсад, төслийн нөлөөлөлд шууд өртсөн орон нутгийн олон нийтийн оролцоог нээлттэй, ил тод байдлаар хангах нь чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ, шаардлагатай тохиолдолд олон улсын сайн туршлага (ОУСТ), компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд бусад талуудын оролцоог мөн хангах нь чухал хэмээн үзэж байна. Талуудын оролцоог хангаснаар тухайн төслийн байгаль орчин, нийгмийн тогтвортой байдал сайжирдаг. Ялангуяа, төслийн цар хүрээ, мөн чанарт тохирсон үр дүнтэй олон нийтийн оролцоо нь төслийн байгаль орчин, нийгэм, санхүүгийн арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг сайжруулан, тогтвортой түвшинд дэмжих ба олон нийтийн хүртэх үр ашгийг нэмэгдүүлнэ. Төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөлөл, асуудлуудыг үр дүнтэйгээр удирдан зохион байгуулахад талуудын оролцоо нь ихэд чухал бөгөөд олон нийттэй үр бүтээлтэй, хариуцлагатай, сайн харилцааг бий болгоход мөн голлох үүргийг гүйцэтгэдэг. Үр дүнд хүрэх үүднээс талуудын оролцоог тухайн төслийн эхний шатнаас л хангаж эхлэх нь зүйтэй.

Банкны Байгаль орчин, нийгмийн томоохон бодлогын нэг хэсэг болох Гүйцэтгэлийн шаардлага 10 (ГШ10)-ын дагуу байгаль орчин, ажиллагсад болон төслийн (А ангиллын) шууд нөлөөлөлд өртсөн орон нутгийн олон нийтэд байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, асуудлууд учруулж болзошгүй бүхий л төслүүд өөрийн БОНМС, төслийн байгаль орчин, нийгмийн үнэлгээ, БОНМТ-ийн хүрээнд төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй талуудыг тодорхойлон тэдний оролцоог хангана.

ГШ10-ыг хангах шаардлагатай төслүүд нь төслийн шууд нөлөөлөлд өртөж буй олон нийт болон бусад холбогдох талуудын оролцоог хангахдаа цаг тухай бүрт, тэдэнд хамааралтай мэдээлэл, асуудлыг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх ба оролцооны үйл явцад аливаа булхай, гадны оролцоо, албадлага, сүрдүүлэг гарахаас сэргийлэн талуудын соёл, уламжлалын хэлбэрт тохирсон байдлаар оролцооны арга хэмжээг зохион байгуулна. Талуудын оролцоог хангах болон ГШ10-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг ЕСБХБ-ын Байгаль орчин, нийгмийн бодлогоос харж болно.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй төслийн хувьд зээлдэгч нь төслийн оролцогч талуудыг тодорхойлж, талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг боловсруулах нь үнэлгээний процессийн салшгүй хэсэг байна. Төслийн төлөвлөгөө, хэрэгжилт, үйл ажиллагаанд тусгах оролцогч талуудын үзэл бодол, саналыг авахын тулд хэлэлцүүлэг зөвлөгөөн хийх шаардлагатай. Зээлдэгч нь төслийн нөлөөлөлд өртөж болзошгүй ба/буюу төслийн талаар сонирхож буй оролцогчдыг тодорхойлж, тэдэнд төслөөс үүдэн бий болох үр нөлөө, асуудлуудын талаар бүрэн дүүрэн мэдээлэл өгч, төсөлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл, анхаарал татах түвшин зэргийг харгалзан талуудын оролцоог хангана.

А ангиллын төслүүдийн хувьд зээлдэгч болон Банк нь БОННУ-ийн баримт бичгийг нийтэд нээлттэй болгоно. Хувийн хэвшлийн төслүүдийн БОННУ-ийг төслийг Зөвлөлийн хурлаар авч хэлэлцэхээс багадаа хуанлийн 60 хоногийн өмнө, төрийн төслүүдийн БОННУ-ийг Зөвлөлийн хурлаар авч хэлэлцэхээс хуанлийн 120 хоногийн өмнө нийтэд ил болгоно. Зээлдэгч нь БОННУ-ийн баримт бичгийг бэлтгэн боловсруулах ба ЕСБХБ тэдгээрийг аливаа санал шүүмж, дэмжсэн өнгө аясгүйгээр нийтэд ил болгоно. БОТБГ нь тухайн БОННУ-ийг хэлэлцүүлэн зөвлөлдөх үйл явцад тохирох шаардлагыг хангасан эсэхийг нийтэд ил болгохын өмнө нягталж үзнэ.

Үүнээс гадна ЕСБХБ-ын ГШ нь биет нүүлгэн шилжүүлэлт ба/буюу эдийн засгийн хохирол учруулахуйц, эсхүл нутгийн уугуул иргэдэд нөлөөлөхүйц төслүүдийг хэлэлцүүлэхэд тавигдах тусгайлсан шаардлагуудыг мөн агуулсан болно.

11. Гомдол барагдуулах механизм

Зээлдэгч нь төсөлтэй холбоотой оролцогч талуудын санаа зовоосон асуудлуудыг ойлгож мэдэн, цаг тухайд нь хариу өгч байхыг ЕСБХБ-аас шаарддаг. Энэ зорилгоор зээлдэгч нь төслийн байгаль орчин, нийгмийн ажиллагааны талаарх оролцогч талуудын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх механизм, үйл явцыг бий болгосон байна. Санал гомдлын механизмын хамрах хүрээг төслөөс үүдэн бий болж болзошгүй эрсдэл, нөлөөллийн цар хэмжээтэй уялдуулсан байна.

- Санал гомдлыг барагдуулах журам, механизм нь соёл, зан заншлын хувьд зохимжтой, нөлөөлөлд өртсөн бүхий л олон нийтэд ойлгоход хялбар, ил тод байх шаардлагатай ба олон нийтийн санаа зовоосон асуудлуудыг түргэн шуурхай, үр дүнтэй, мөн ямарваа нэг шийтгэл оногдуулахгүйгээр шийдвэрлэдэг байхаар зохион байгуулагдсан байх ёстой. Энэхүү гомдол барагдуулах журам, механизм нь олон нийтийг шүүх, засаг захиргаанд гомдлоо гаргах явдалд саад тотгор учруулах ёсгүй. Зээлдэгч нь олон нийтийг татан оролцуулах ажиллагааны явцад санал гомдлын механизмын тухай нөлөөлөлд өртсөн холбогдох олон нийтэд мэдээлэх бөгөөд түүний биелэлтийг олон нийтэд тогтмол тайлагнах ба хүмүүсийн хувийн нууцыг хамгаална.
- Санал гомдлыг соёл, зан заншлын хувьд зохистой, тохиромжтой хэлбэрээр барагдуулах нь зүйтэй бөгөөд талуудын хэрэгцээ, санал бодолд бодитой, шударга, хариуцлагатай хандах ёстой. Мөн энэхүү механизм нь дурын санал гомдлыг хэлэлцүүлэх боломжийг олгосон байна.

ЕСБХБ нь түүнчлэн Банкнаас санхүүжүүлсэн төслүүдийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх Төслийн гомдлын механизм (ТГМ) гэх өөрийн гэсэн хариуцлагын механизмтай. Энэ нь ЕСБХБ-ын төслийн шууд эсхүл сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хувь хүн (хүмүүс) болон дотоодын бүлгүүд, иргэний нийгмийн байгууллагуудын Банкинд хандан банкны үйл ажиллагаанаас тусдаа санал гомдол гаргах хэрэгсэл юм.

ТГМ нь 2 чиглэлтэй. Үүнд:

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

- Банкны батласан төсөл нь ЕСБХБ-ын бодлогууд, ялангуяа байгаль орчны холбогдох бодлогууд, Нийтэд мэдээлэх бодлогын төсөлтэй холбоотой заалтуудыг сахин хангаж буй эсэхийг үнэлдэг Нийцлийн хяналт, болон
- Гомдол санал үүсгэж буй асуудлуудыг аль болох шийдвэрлэх үүднээс талуудын хооронд яриа хэлэлцээ өрнүүлэн сэргээх зорилго бүхий Асуудлыг шийдвэрлэх санаачлага. Асуудлыг шийдвэрлэх санаачлага гэдэгт бие даан баримт цуглуулах, зуучлах, эвлэрүүлэх, яриа хэлэлцээ өрнүүлэх, шинжилгээ хийх, тайлагнах зэрэг багтана.

Гомдол саналд үнэлэлт дүгнэлт хийсний дараа Нийцлийн шалгалт ба/буюу Асуудал шийдвэрлэх санаачилга ашиглах, эсхүл алийг нь ч ашиглахгүй байх зөвлөмж гарч болно.

12. Мониторинг

ЕСБХБ-ын Байгаль орчин, нийгмийн бодлого, Байгаль орчин, нийгмийн зарчмууд нь Гүйцэтгэлийн шаардлагуудын хэрэгжилтийг хянах замаар өөрийн хөрөнгө оруулалтын Байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлд мониторинг хийх арга хандлага, процессийг тодорхойлсон байдаг. Үүнд зээлдэгчдийн хийх мониторинг, хүлээн авсан тайлангуудыг судлан үзэх замаар ЕСБХБ-ын ажилтнуудын хийх мониторинг болон гуравдагч талын мониторинг багтана. Үүнд оролцогч талуудын санаа бодлыг тусгаж, шаардлагатай бол байгаль орчин, нийгмийн төслүүдийн гүйцэтгэлд хийх хяналт, аудит зэргийг хамруулж болно. Мониторингийн хамгийн наад захын шаардлага ёсоор ЕСБХБ нь төслийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийн талаар зээлдэгчийн бэлтгэн ирүүлсэн Байгаль орчин, нийгмийн жилийн тайлан, тухайлбал Байгаль орчин, нийгмийн менежментийн ба/буюу үйл ажиллагааны төлөвлөгөөг хянана. ЕСБХБ нь тодорхой хугацааны давтамжтайгаар Банкны байгаль орчин, нийгмийн мэргэжилтнүүд, эсвэл бие даасан экспертүүдийг төслийн талбайд ажиллуулан тэдний бэлтгэсэн мэдээллийг хянах замаар мониторинг мөн явуулж болно.

Хэрэв зээлдэгч гэрээний баримт бичгүүдэд заасан нийгэм, байгаль орчны үүрэг хариуцлагаа биелүүлээгүй бол ЕСБХБ хэрэгжилтийг хангахад шаардагдах засч залруулах нэмэлт арга хэмжээ авах талаар зээлдэгчтэй тохиролцож болно. Хэрэв зээлдэгч тохирсон нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлээгүй тохиолдолд ЕСБХБ шаардлагатай гэж үзвэл санхүүжилтийн гэрээнд заасан болон засч залруулах арга хэмжээ авч болно. ЕСБХБ төсөлтэй холбоотой үйл ажиллагааг сайжруулах аливаа боломжийн талаар зээлдэгчтэй хамтран судалж үзнэ.

13. Хавсралтууд

- Хориглосон үйл ажиллагааны жагсаалт (Хөтөлбөрөөс санхүүжүүлэхгүй үйл ажиллагааны жагсаалт)
- Хяналтын шалгах хуудас
- Талуудын оролцоог хангах хөтөлбөрийн тойм

Дэд хавсралт 1: ЕСБХБ-ын Байгаль орчин, нийгмийн хориглосон үйл ажиллагааны жагсаалт

ЕСБХБ дараах бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбогдсон төслүүдийг санаатайгаар шууд, эсвэл шууд бусаар санхүүжүүлэхгүй. Үүнд:

- (a) төсөл хэрэгжиж буй орны хууль тогтоомж, олон улсын гэрээ конвенциор хууль бус гэж үзсэн, эсвэл олон улсын шат дараатайгаар татаж авах ажиллагаа, хоригт хамрагдсан аливаа бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, аливаа үйл ажиллагаа явуулах, тухайлбал:
 - (i) полихлорт бифенил (PCB буюу ПХБ) агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, худалдах⁵;
 - (ii) олон улсын үе шаттайгаар татаж авах ажиллагаа, хоригийг зөрчсөн эм; пестицид/гербицид болон бусад аюултай бодисыг үйлдвэрлэх, худалдах⁶;
 - (iii) олон улсын үе шаттайгаар татаж авах ажиллагаанд хамаарах озоныг задлах зүйлсийг үйлдвэрлэх, худалдах⁷;
 - (iv) зэрлэг амьтны ба ургамлын аймгийн ховордсон төрөл зүйлсийн олон улсын худалдааны тухай конвенц (CITES - ХЗОУХК)-аар зохицуулагддаг зэрлэг ан амьтныг худалдах, зэрлэг ангийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах⁸;
 - (v) олон улсын хуулиар хориглосон хаягдлыг хил дамнуулан тээвэрлэх⁹ зэрэг үйл ажиллагаа орно.
- (b) асбестан наалдаагүй зөөлөн эд эсхүл асбест агуулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, ашиглах, худалдах,
- (c) биологийн олон янз байдал, эсвэл соёлын өв уламжлалыг хамгаалах тухай хүлээн авагч орны хууль, тогтоомж буюу олон улсын конвенциор хориглосон үйл ажиллагаа¹⁰,

⁵ PCB: Полифлоринатжуулсан бифенил маш хортой химийн бодисын бүлэг. 1950-1985 оны үеийн тосоор дүүргэсэн цахилгаан трансформатор, конденсатор болон хуваарилах төхөөрөмжинд PCB орсон байдаг.

⁶ Ишлэл: Зарим аюултай химийн бодисын экспорт ба импортын тухай нэмэлт өөрчлөлт оруулсан ЕХ-ны журам (ЕЕС) 2455/92, Засгийн газруудаас хэрэглээ болон/эсвэл худалдааг нь хорисон, татан авсан, хатуу хязгаарласан эсвэл батлаагүй бүтээгдээний НҮБ-ын нэгдсэн жагсаалт, Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай конвенци (Роттердамын конвенци), Тэсвэртэй органик бохирдуулагчийн тухай Стокгольмын конвенци, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын пестицидийн аюулын ангилал.

⁷ Озоны үе давхаргыг задалдаг бодисууд (ОЗБ): “Озоны цоорхой” бий болгоход хүргэдэг стратосферийн озонтой урвалд орж түүнийг задладаг химийн бодисууд. Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухай Монреалын протоколд эдгээр бодисуудыг багасгах, аажмаар устгах зорилтот хугацааг дурдсан байдаг. Аэрозоль, хөргөх бодис, хөөс үлээгч бодис, уусгагч болон галаас хамгаалах бодисыг багтаасан Монреалийн протоколоор зохицуулагддаг химийн бодисын жагсаалтад гарын үсэг зурсан орнуудын эдгээр бодисыг хэрэглээнээс хасах, устгах зорилтот хугацааны талаарх мэдээллийг НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрөөс авч болно.

⁸ CITES: Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенци. CITES конвенцийн хүрээнд хамгаалагдсан зүйлсийн жагсаалтыг CITES-ийн ажлын албанаас авч болно.

⁹ Ишлэл: Хаягдал зөөвөрлөх тухай журам (ЕС) 1013/2006, Нөхөн сэргээлтэд зориулсан хаягдлыг хил давуулан тээвэрлэх ажиллагаанд тавих хяналтын тухай эцсийн шийдвэр C(92)39-ийн өөрчлөлттэй хамаатай Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын зөвлөлийн эцсийн шийдвэр C(2001) 107, Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн конвенци.

¹⁰ Холбогдох олон улсын конвенциуд: Зэрлэг амьтдын нүүдлийн зүйлүүдийг хамгаалах тухай конвенци (Бонны конвенци); Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенци (Рамсар конвенци); Европын зэрлэг ан амьтан ба байгалийн амьдрах орчныг хамгаалах тухай конвенци (Берны конвенци); Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци; Биологийн олон янз байдлын тухай конвенци.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

- (d) 2.5 км-аас илүү урт тор ашиглан далайд тор хөвүүлэн загас барих,
- (e) олон улсын далайн байгууллага (ИМО)-ын шаардлагыг хангаагүй ачааны усан онгоцонд газрын тос болон бусад аюултай бодис материал тээвэрлэх¹¹,
- (f) шаардлагатай экспорт, импортын лицензгүй, эсвэл экспорт, импорт хийж байгаа холбогдох орны транзитын зөвшөөрөлгүй барааг худалдах, транзитаар тээвэрлэх үйл ажиллагаанууд орно.

¹¹ Эдгээрт: Далайг хөлөг онгоцноос бохирдуулахаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын конвенци (MARPOL), Далайд хүний аюулгүй ажиллагааг хангах тухай олон улсын конвенци (SOLAS)-ийн дагуу холбогдох сертификат аваагүй (мөн Олон улсын аюулгүй ажиллагааны менежментийн дүрэм зэрэг бусад шаардлагууд) ачааны усан онгоцууд, ЕХ-ны хар жагсаалтад орсон, эсвэл Боомт бүхий улсуудын хяналтын талаарх харилцан ойлголцлын тухай Парижийн санамж бичиг (Парижийн харилцан ойлголцлын санамж бичиг)-ийн дагуу үйл ажиллагааг нь хориглосон, түүнчлэн MARPOL-ийн 13G заалтын дагуу аажмаар хасагдах усан онгоцууд тус тус багтана. Их бие нь 25 жилээс илүү болсон аливаа ачааны усан онгоцыг ашиглахгүй байвал зохино.

Дэд хавсралт 2: Хяналтын шалгах хуудас

Танилцуулга

Нийцлийн хураангуй нь холбогдох Гүйцэтгэлийн шалгуурууд (ГШ)-ын дагуу тодорхойлсончлон ЕСБХБ-ын Байгаль орчин, нийгмийн бодлогын дагуу байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллүүдийг тодорхойлоход системчилсэн хяналт шалгалт хийх шалгах хуудастай байна. Нийцлийн хамрах хүрээнд Санхүүгийн зуучлалын бус төслүүдэд хамаарах бүх ГШ байна. Хяналт шалгалт нь байгаль орчин, нийгмийн жилийн тайлагналын үйл явцаар дамжуулан төслүүдийн ирээдүйн гүйцэтгэлийг үнэлж дүгнэхэд ашиглах суурь үнэлгээг гаргах зорилготой болно.

Заавар

Бүх ГШ (бүхэл тоон дугаарлалттай үзүүлэлтүүд)-д тухайн ГШ-ыг хангасан эсэхийг тоймлон үзүүлнэ. ГШ хангаагүй аливаа үзүүлэлтийн үнэлэлт дүгнэлтийг тоймлон, дагалдах баримт бичгийг хавсаргана.

ГШ-ын үзүүлэлт тус бүр дээр дараах 3 алхамыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 1. Үзүүлэлт хэрэглэгдэх эсэхийг шийдвэрлэх.** А болон В ангиллын төслүүдийн хувьд тухайн төсөл нь үзүүлэлттэй холбоотой ноцтой асуудалгүй (ө.х. эрсдэлгүй) бол бүх үзүүлэлтүүд хэрэглэгдэх ба үзүүлэлтийг “ЭХ” гэж үнэлэх ба шалтгааныг товч тайлбарлана. С ангиллын төслүүдийн хувьд тухайн төсөл нь үзүүлэлттэй холбогдох ноцтой асуудалтай бол (ө.х. материалын эрсдэлтэй) бүх үзүүлэлт “ЭХ” байна.
- 2. Санал гаргах боломжтой эсэхийг шийдвэрлэх.** Хэрэв боломжгүй бол (жишээ нь үзүүлэлт хэрэглэсэн ч төслийн хувьд хэтэрхий эрт байх тохиолдолд) “СГБ” гэж үнэлэн шалтгааныг товч тайлбарлана. Хяналт шинжилгээнд материаллаг үл нийцэл байгаагаас санал гаргах боломжгүй бол тайлангийн зохих хэсэгт хамаарах аливаа зөвлөмжийг товч багтаана.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

4. Үзүүлэлтүүдийг дараах байдлаар үнэлж, товч тайлбарыг оруулна.

ДН	Давсан Нийцэл: Төсөл нь ЕСБХБ-ын ГШ-ыг давуулан хангасан. ЕСБХБ нь ХН үнэлгээтэй төслүүдийг Байгаль орчин, нийгмийн эерэг нөлөөллийн жишиг загвар болгон ашиглагаж болно.
БН	Бүрэн Нийцэл: Төсөл нь ЕСБХБ-ын шаардлагууд, ЕХ болон дотоодын байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого, чиглэлийг бүрэн хангасан.
ХН	Хэсэгчилсэн Нийцэл: Төсөл нь ЕСБХБ-ын шаардлагуудыг бүрэн хангаагүй хэдий ч дутагдалтай байгаа зүйлийг шийдвэрлэх системтэй, эсхүл нөлөөллийг бууруулах арга хэмжээ хэрэгжүүлж байгаа.
МҮН	Материаллаг үл нийцэл: Төсөл нь ЕСБХБ-ын шаардлагуудыг материалын хувьд хангаагүй бөгөөд одоо байгаа процесс, нөлөөллийг бууруулах арга хэмжээ нь дутагдалтай байгаа зүйлсийг нөхөж чадахгүй байгаа.

5. **Тайлбар/Асуудал:** Энэхүү шаардлагын төсөлд хамаарах байдлын талаар товч тайлбар хийж, сонгосон оноог тайлбарлана.

6. **Шаардлагатай арга хэмжээ:** Шаардлагатай тохиолдолд зээлдэгчийн зүгээс шаардлага бүрийг бүрэн хангахад шаардлагатай арга хэмжээг товч тайлбарлана. Тухайн төслийн БОНАТ-д холбогдох арга хэмжээг тусгасан бол БОНАТ-ийг иш татна уу.

7. **ГШ-ын тойм:** Дээрх нийцлийн тодорхойлолтуудыг дагалдах тайлбартайгаар ашиглан ГШ-тай тулган ерөнхий дүгнэлт хийнэ. Зарим тохиолдолд дээрх үе шат 1-ээс хамааран ГШ-ыг зөвхөн дүгнэлтийн хэсэгт дурдах нь хангалттай байж болно.

Тайлбар: Материаллаг үл нийцлийн оноо (Үзүүлэлтийн болон ГШ-ын түвшин дэх аль аль нь) төсөл батлагдахад чухал үүрэг гүйцэтгэх тул үүнд хянамгай хандах шаардлагатай. Арга хэмжээ нь дутагдалтай байгаа зүйлсийг хангалттай нөхөхүйц эсэхийг үнэлж дүгнэхдээ зөвлөх нь тухайн төслийн үлдэгдэл эрсдэл (батлагдсаны дараах) болон БОНАТ-аар дамжуулан асуудлыг бодлогод нийцүүлэн төслийг амжилттай болгох баталгааг хамтад нь харгалзан үзэх шаардлагатай. Доорх хүснэгтэд ашиглах арга хандлагыг үзүүлэв.

Эрсдэл	Их	ХН	МҮН	МҮН
	Дунд	ХН	ХН	МҮН
	Бага	БН	ХН	ХН
		Их	Дунд	Бага

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Баталгаа

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
1	Байгаль орчин, нийгмийн нөлөөлөл ба асуудлын үнэлгээ				
	Хураангуй:				
1.1	Байгаль орчин, нийгмийн үнэлгээ				
1.2	Байгаль орчин, нийгмийн менежментийн систем				
1.3	Байгаль орчин, нийгмийн бодлого ¹²				
1.4	Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө				
1.5	Байгууллагын чадавхи болон үүрэг амлалт				
1.6	Ханган нийлүүлэлтийн сүлжээний менежмент				
1.7	Төслийн мониторинг ба тайлагнах үйл ажиллагаа ¹³				
2	Хөдөлмөр эрхлэлт ба ажиллах нөхцөл				
	Хураангуй:				
2.1	Хүний нөөцийн бодлого ба ажлын харилцаа				

¹² Зээлдэгч үйл ажиллагаагаа ихээхэн хэмжээгээр өргөтгөж байгаа тохиолдолд Бодлого болон дагалдах менежментийн систем болон төлөвлөгөө нь шинэ үйл ажиллагаанд тохиромжтой эсэх.

¹³ Үнэлгээний шатанд мэдээлэл хязгаарлагдмал байна. Нийцлийн үнэлгээнд мониторинг бай тайлагналын тодорхой төлөвлөгөөнүүдийг авч үзэх (жишээ нь, БОНАТ-ын шаардлагуудтай тулгах) ба зээлдэгчийн бусад төслүүдэд ирээдүйн гүйцэтгэлийн баталгааг бууруулж болзошгүй сул мониторинг/тайлагнал бий эсэхийг харгалзан үзэх.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
2.2	Хүүхдийн ба албадан хөдөлмөр				
2.3	Үл ялгаварлан гадуурхах ба ижил боломж олгох				
2.4	Ажиллагсдын байгууллагууд				
2.5	Цалин, урамшуулал, хөдөлмөрийн нөхцөл ба ажлын байр				
2.6	Цомхотгол ¹⁴				
2.7	Гомдол барагдуулах механизм				
2.8	Гэрээт ажилтнууд				
2.9	Ханган нийлүүлэлтийн сүлжээ				
2.10	Хамгаалалтын ажилтнуудад тавигдах шаардлагууд				
3	Нөөцийн үр ашигтай хэрэглээ, бохирдлоос сэргийлэх ба хяналт тавих Тайлбар: Үнэлгээ хийхдээ нийцлийн үнэлгээнд ямар дүрэм журам, стандарт (<i>тухайлбал, ЕХ-ын, Үндэсний, салбарын сайн туршлага</i>) үйлчилдгийг анхааралтай авч үзэх (онцлон тэмдэглэх). Үнэлгээнд боломжит арга техникийг харгалзан үзсэн эсэхийг авч үзэх.				
	Хураангуй:				
3.1	Нөөцийн зохистой ашиглалт				
3.2	Бохирдлоос сэргийлэх ба хянах – Агаарын бохирдол ялгаруулалт				
3.3	Бохирдлоос сэргийлэх ба хянах – Хаягдал, бохир ус				

¹⁴ Үнэлгээний шатанд ихэнх төслүүдэд хамаарахгүй. Гэхдээ зээлдэгчийн зүгээс сүүлийн 3 жилд Бодлогод үл нийцэх аливаа цомхотгол хийсэн нотолгоо бий бол түүнийг харгалзан үзнэ.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
3.4	Хүлэмжийн хий ¹⁵				
3.5	Ус				
3.6	Хаягдал				
3.7	Аюултай бодис ба материал				
4	Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа				
	Хураангуй:				
4.1	Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа				
4.2	Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа				
4.3	Дэд бүтэц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн зураг төсөл ба аюулгүй ажиллагаа				
4.4	Аюултай материалын аюулгүй ажиллагаа				
4.5	Бүтээгдэхүүн, үйлчилгээний аюулгүй байдал				
4.6	Замын хөдөлгөөн ба замын аюулгүй байдал				
4.7	Байгалийн гамшиг				
4.8	Өвчлөлийн эрсдэл				
4.9	Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ				

¹⁵ Зээлдэгч өөр хувилбаруудыг судалж үзсэн эсэхэд анхаарал хандуулах шаардлагатай. Жилд 25000 тоноос их хэмжээний нүүрсхүчлийн хий ялгаруулах төслүүд жилийн тайландаа бохирдол ялгаруулалтын бараа материал, төлөвлөгөөг тайлагнана.

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
5	Газар чөлөөлөх, албадан нүүлгэн шилжүүлэх ба эдийн засгийн хохирол амсах				
	Хураангуй:				
5.1	Нүүлгэн шилжүүлэлтээс зайлсхийх буюу багасгах				
5.2	Зөвшилцөл				
5.3	Нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн этгээдэд нөхөн олговор олгох				
5.4	Гомдол барагдуулах механизм				
5.5	Нүүлгэн шилжүүлэх/Амьжиргааг сэргээх үйл ажиллагааны баримтжуулалт				
5.6	Нүүлгэн шилжүүлэх/Амьжиргааг сэргээх үйл ажиллагааны хэрэгжилт				
5.7	Мониторинг				
6	Биологийн олон төрөл зүйл ба байгалийн амьд нөөц				
	Хураангуй:				
6.1	Биологийн олон төрөл зүйл, байгалийн амьд нөөцийн үнэлгээ				
6.2	Биологийн олон төрөл зүйлийг хамгаалах				
6.3	Байгалийн амьд нөөцийн тогтвортой менежмент				

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
7	Нутгийн уугуул иргэд				
	Хураангуй:				
7.1	Нутгийн уугуул иргэдийн үнэлгээ				
7.2	Сөрөг нөлөөнөөс зайлсхийх ба Нутгийн уугуул иргэдийн хөгжлийн төлөвлөгөө				
7.3	Мэдээллийг ил тод болгох, үр дүнтэй зөвлөлдөх ба мэдээллээр хангасан оролцоо				
7.4	Санал гомдлын механизм ба үндэс угсаанаас шалгаалсан ялгаврлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх				
7.5	Нөхөн олговор ба үр шимийг хуваалцах				
7.6	Нөлөөлөл/Уламжлалт болон за үйлийн газар нутгаас нүүлгэн шилжүүлэх ба соёлын өв				
8	Соёлын өв				
	Хураангуй:				
8.1	Соёлын өвд учирч болзошгүй нөлөөллийн үнэлгээ ба менежмент				
8.2	Нөлөөлөлд өртсөн олон нийт ба бусад талуудтай зөвлөлдөх				
8.3	Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанд ашиглах				

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

ГТҮ дугаар	Гүйцэтгэлийн шаардлага	Оноо	Тайлбар/Асуудал	Шаардлагатай арга хэмжээ	БОНАТ дугаар
10	Мэдээллийг ил тод болгох, талуудын оролцоо				
	Хураангуй:				
10.1	Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө				
10.2	Үйл ажиллагааны санал гомдлын механизм				
	Ерөнхий нийцэл				
	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын үндэсний шаардлагууд				
	Байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй байдлын ЕХ-ын шаардлагууд				

АЛБАН ХЭРЭГЦЭЭНД

Дэд хавсралт 3: Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө боловсруулах зааварчилгаа

Талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг боловсруулахдаа багтаасан байвал зохих асуудлуудыг дор жагсаалтаар үзүүлэв. Зөвлөх нь тухайн төсөлд аль асуудал (доор жагсаасан болон нэмэлт) холбогдол бүхий болохыг мэргэжлийн үүднээс үнэлж тодорхойлно. Үүнд:

Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө нь:

- Төслийн байршил, нөлөөлөлд өртөж болзошгүй хэсгүүдийг (тухайлбал, бүлгүүдийг) товч тодорхойлсон
- Төсөл нь мэдээллийг ил болгох болон зөвлөлдөх хэлэлцээ хийхэд хууль ёсоор юу хийх шаардлагатайг бүртгэн тэмдэглэсэн
- Оролцогч бүх талуудыг, тухайлбал оролцогч талуудын зураглалыг (хэрэв холбогдолтой бол) тодорхойлсон
- Бичиг үсэг тайлагдсан түвшин, жендэр, нийгэм-эдийн засгийн түвшин, үндэс яс/хэл, эсхүл байршил (тухайлбал, төсөл нь сургууль, эмнэлэг, гэх мэтэд ойр байдал) зэргээс шалтгаалан эмзэг эсхүл илүү дэмжлэг шаардлагатай тодорхой бүлгүүдийг зөвлөлдөх явцад тодорхойлсон бөгөөд тодорхойлсон бүлэг бүрт зөвлөлдөх үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлж болохыг заасан
- Өмнө нь хийгдэж байсан аливаа зөвлөлдөх үйл ажиллагаа, мэдээллийг ил болгох үйл явцын талаар тайлагнасан
- Ямар баримт бичиг гаргахаа тодорхойлсон, тухайлбал хуваарь, ямар хэл дээр, гэх мэт.
- Баримт бичгийг хэрхэн нийтийн хүртээл болгохоо тодорхойлсон (биет болон цахим хаягууд), тухайлбал тодорхой сонин, эмхэтгэлийн самбарын нэр байршлыг заах, гэх мэт.
- Баримт бичиг нийтийн хүртээл болж буйг хүмүүст хэрхэн мэдэгдэхээ тодорхойлсон
- Зөвлөлдөн хэлэлцэх үйл ажиллагааны эхлэх болон дуусах огноог заасан
- Санал сэтгэгдэл хүлээн авах хурал уулзалт, үйл ажиллагаа, арга хэмжээнүүдийн жагсаалтыг гаргасан, хэрэв байршил/огноо нь хараахан тодорхой болоогүй бол эдгээрийг хүмүүст хэрхэн мэдэгдэх арга замаа тодорхойлсон
- Санал сэтгэгдлийг хэнд/хааш нь илгээх, тэдгээрийг дараа нь яах, үр дүнг нь хүмүүст хэрхэн мэдээлэх зэргийг заасан
- Гомдлыг хэрхэн шийдвэрлэх арга замыг тодорхойлсон (олон нийтийн гомдол шийдвэрлэх тодорхой процессийг багтаана)
- Талуудын оролцооны мониторинг болон тайлагнах үйл ажиллагааг тодорхойлсон
- Талуудын оролцооны үйл ажиллагааг хангах үүрэг хариуцлагыг тодорхойлсон байх шаардлагатай.

Талуудыг татан оролцуулах төлөвлөгөө нь товч тодорхой бөгөөд хавсралтуудыг оруулахгүйгээр 15 хуудас байна.

Зааварчилгааг доорх холбоосоор орж дэлгэрэнгүй үзнэ үү.

<http://www.ebrd.com/downloads/about/sustainability/grievance-mechanism.pdf>